



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-36
<hr/>	
1.Хуулийн төслийг эцэслэн батлах	4-5
2.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандан “Малчдад тулгамдаж байгаа асуудлын талаар” тавьсан асуулгын хариуг сонсох	6-36

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 13-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 51.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 07 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адьяаа, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Н.Учрал, О.Цогтгэрэл, Ж.Чинбүрэн;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Ё.Баатарбилэг, Ц.Даваасүрэн, Б.Жавхлан, Л.Оюун-Эрдэнэ, Д.Өнөрболор, Д.Сарангэрэл, Г.Тэмүүлэн;

Эмнэлгийн чөлөөтэй: М.Оюунчимэг;

Хоцорсон: Н.Алтанхуяг- 07 минут, С.Батболд- 12 минут, Э.Батиугар- 08 минут, Б.Баярсайхан- 03 минут, Д.Ганбат- 16 минут, Г.Ганболд- 08 минут, Ц.Сандаг-Очир- 03 минут, Ч.Хүрэлбаатар- 12 минут, Д.Цогтбаатар- 25 минут, Б.Энх-Амгалан- 05 минут;

Тасалсан: Ц.Анандбазар, Б.Бейсен, С.Ганбаатар, Ж.Сүхбаатар, Ц.Туваан.

Нэг.Хуулийн төслийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референтийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Наранцэцэг нар байлцав.

Г.Занданшатар: 1.Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 6
Бүгд: 42
85.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 8
Бүгд: 45
82.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэгдсэн хуралдааны ирц хүрээгүй учир хэлэлцэх асуудлыг хойшлуулав.

Үдээс өмнөх хуралдаан 12 минут үргэлжилж, 72 гишүүнээс 45 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 10 цаг 19 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 06 минутаас эхлэв.

Хоёр.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандан “Малчдад тулгамдаж байгаа асуудлын талаар” тавьсан асуулгын хариуг сонсох

Асуулгын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Наранчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Салбарын хяналтын газрын дарга Б.Санчирдорж, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын ахлах референт Г.Анар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референтийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Наранцэцэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Янжинхорлоо, мөн хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг нар байлцав.

Асуулгын хариуг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун танилцуулав.

Асуулгын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, С.Чинзориг, Б.Бат-Эрдэнэ, Ж.Батжаргал, Б.Баярсайхан, Ц.Сандаг-Очир, Т.Аубакир, Ж.Батсуурь, Б.Энх-Амгалан, Г.Ганболд нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Наранчулуун, Салбарын хяналтын газрын дарга Б.Санчирдорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан нар үг хэлэв.

Нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандан “Малчдад тулгамдаж байгаа асуудлын талаар” тавьсан асуулгын хариуг сонслоо.

Уг асуудлыг 16 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Бусад.Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны урилгаар Төв аймгийн Бүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 1990 оны төгсөгчид Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхцоож, шинжээч С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 2 цаг 11 минут үргэлжилж, 72 гишүүнээс 50 гишүүн хүрэлцэн ирж, 69.4 хувийн ирцтэйгээр 16 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 07 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 13-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 3 асуудал хэлэлцэнэ.

1 дүгээрт, хуулийн төслүүдийг эцэслэн батална. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн батална.

Энэ зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал чинь, тогтоол энэ тэр нь гараагүй учраас үүнийг хойшлуулчихъя.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайханаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандаж “Малчдад тулгамдаж байгаа асуудлын талаар” тавьсан асуулгын хариуг сонсоно. Болорчулуун сайд мэдэж байгаа, тийм ээ.

Ийм асуудлууд хэлэлцэнэ. Ингээд хэлэлцэх асуудалдаа орно.

Хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Тогтохсүрэн дарга аа, Тогтохсүрэн дарга. Хуулийн төслүүд эцэслэн батална. Нийт гишүүний олонхоор батлах юм байна.

Балжиннямын Баярсайхан гишүүн ээ. Үдээс хойш асуулгын, картаа хийгээд уншуулаарай, 39 болно.

Энэ Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн 2 өдөр чуулган тасалж байна. Хаачсан бэ? Цэрэнпилийн Даваасүрэн сайд. Энэ төсөв Засгийн газрын чухал асуудал хэлэлцэж байхад энэ сайд нар, Даваасүрэн сайдын тэр ирцийг гаргаж ирж танилцуул. Жамбалын Ганбаатар сайд, Хүрэлбаатарын Булгантуяа сайд. Хууль эцэслэн батлахад хүрээд ирчихмээр байна. Сүхбаатарын Батболд. Чимэдийн Хүрэлбаатар сайд хаачсан?

Бямбасүрэнгийн Энх-Амгалан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга 12 минут 2 секунд хоцорлоо.

Хуулийн төслүүдийг эцэслэн батална. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д 7 хоногийн Баасан гарагийн 10 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Хуралдааны ирц хуулийн төслийг эцэслэн батлах шаардлага хангахаар бол бусад өдөр, цагт хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулж болно гэж заасан.

Байнгын хороод хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах хувилбарыг бэлтгэн, гишүүдэд тарааж, эцэслэн батлуулахад бэлэн болсон байна. Одоо төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Санал хураалтад бэлтгэе.

Эцэслэн батлахад үг хэлэхгүй, хэлэлцүүлэг дуусчихсан. Одоо эцэслэн батлах л санал хураалт.

Цэдэвийн Сэргэлэн гишүүн, нөхөр генерал Сэргэлэн суудалдаа сууя. Санал хураалт явуулъя. Эрхэм гишүүн Норовын Алтанхуяг чуулганы танхимд морилж, 13 минут 42 секунд хожигдсон байна. Өглөө чөлөө авсан.

Ингээд хууль эцэслэн батална.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.4.2-т нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд нийт гишүүдийн олонх хуулийг эцэслэн батлахыг дэмжсэнээр хууль эцэслэн баталсанд тооцогдоно гэж заасан байгаа.

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулна. Дархлаажуулалтын тухай хуулийг. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулъя.

Амартүвшин гишүүн гүйгээрэй. Энэ Улсын Их Хурлын гишүүн сайд нар картаа хийчхээд явчихсан. Санал хураалтад оролцохгүй байгаа тул хүрэлцэн ирэхийг шаардаж байна. Хүрэлбаатарын Булгантуяа, Баттогтохын Чойжилсүрэн, Сандагийн Бямбацогт 3, Жамбалын Ганбаатар 4 сайд. Энэ 4 сайд хүрэлцэн ирэхгүй бол.

Ганибалын Амартүвшин гишүүн. Ганибалын Амартүвшин гишүүн.

Г.Амартүвшин: Дарга аа, кнопоо дарж арай амжсангүй. Саяын санал хураалтыг дахиж явуулна уу.

Г.Занданшатар: Амартүвшин гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт. Сая унасан биш л дээ санал хүрээгүй, 85 хувь л болсон. Санал Амартүвшин гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүйд

тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт.

82,2 хувийн саналаар Ганибалын Амартүвшин гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ. Дэмжигдсэн учраас өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Санал хураалтыг дахиж явуулна. Ажиллахгүйн улмаас амжаагүй байх л даа, зайлуул. Ер нь бас энэ төхөөрөмж бол ашиглагдахаа больчихсон, ашиглалтын хугацаа дуусчихсан байгаа юм. Тэгээд шинэчлэхээс өөр аргагүй болчихсон байгаа юм.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны дэгийн хуулийн дагуу хэрвээ ирц шаардлага хангахгүй бол өөр цаг, хугацаанд эцэслэн батлах санал хураалтыг явуулж болно гэж заасны дагуу энэ 4 сайд Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг тасалдуулж байгаа учраас үдээс хойш 14 цаг хүртэл хууль эцэслэн батлах санал хураалтыг хойшлууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг 14 цаг хүртэл. Энэ олонхын бүлэг дангаараа хууль батлах хэмжээний ирц бүрдүүлж байж энэ хуулиуд батлагдана.

Ийм учраас 14 цаг хүртэл чуулганы нэгдсэн хуралдааныг завсарлууллаа.

ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААН.

Г.Занданшатар: Өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 13-ны өдрийн үдээс хойших хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Эхлээд хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Дараа нь Монгол Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайханаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуунд хандаж “Малчдад тулгамдаж байгаа асуудлын талаар” тавьсан асуулгын хариуг сонсоно.

Дараа нь Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ.

Ингээд Монгол Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайханаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандаж “Малчдад тулгамдаж байгаа асуудлын талаар” тавьсан асуулгын хариуг сонсох асуудал эхэлбэ.

Хэлэлцэх асуудалдаа орно.

Ингээд асуулгад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хангаагийн Болорчулуун хариулна. Хаянгаагийн Болорчулуун сайдыг индэрт урьж байна.

Х.Болорчулуун: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр малчдын өмнө тулгамдаж буй асуудлын талаар тухайлбал Монгол Улсын Засгийн газраас малчид, мал аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлж байгаа бодлого, түүний хэрэгжилт, үр дүн, малчдын залуу халааг бэлтгэх, дэмжих, төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн, малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хэрэгжилт, үр дүн, бэлчээрийн даац хэтэрч бэлчээр доройтсонтой холбоотойгоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, ажлын үр дүнгийн талаар асуулга тавьсан.

Манай яам асуулгын хариуг 2023 оны 06 сарын 28-ны өдрийн 01/2334 тоот албан бичгээр Улсын Их Хурлын гишүүн Баярсайханд хүргүүлсэн бөгөөд

өнөөдрийн Улсын Их Хурлын хуралдаанаар асуудлыг хэлэлцүүлэхтэй холбогдуулан өмнөх мэдээллийг шинэчлэн боловсруулж, та бүхэнд танилцуулж байна.

Ингээд та бүхэнд МАА, малчдын залуу халааг бэлтгэх малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар авч хэрэгжүүлж байгаа ажлын товч үр дүнгийн талаарх мэдээлэл хийе. Эдгээр мэдээллийг дэлгэрэнгүй хавсралтаар бэлтгэж хүргүүлсэн байгаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Мал аж ахуйн салбараас жилд дунджаар 500-600 мянган тонн мах, 15-20 сая ширхэг арьс шир, 33-35 мянган тонн ноос, 10100 мянган тонн ноолуур, 750-850 сая литр сүү, 225-250 сая ширхэг өндөг үйлдвэрлэн 2022 оны байдлаар ДНБ-ий 12,6 хувийг, нийт экспортын 5,6 хувийг бүрдүүлж байна.

Улсын хэмжээгээр 22 оны эцэст мал тооллогын дүнгээр 71,1 сая толгой мал тоологдож, өмнөх оноос 3,8 сая малаар өссөн. Мал тооллогын 22 оны дүнгээр нийт малтай өрхийн 76,8 хувь буюу 190 мянган өрх нь жилийн 4 улирлын туршид малаа маллаж, амьжиргааны эх үүсвэрээ бүрдүүлж байгаа малчин өрх байна. Малчин өрхийн тоо өмнөх оноос 2,2 мянга буюу 1,2 хувиар өссөн дүнтэй гарлаа.

Мал аж ахуйн салбар 2023 онд 20,1 сая эх мал төллөж, 17,8 сая төл бойжуулсан. Ингэснээр энэ оны 9 дүгээр сарын сүүлийн байдлаар 80 сая толгой мал өнөөдрийн байдлаар бэлчээрлэж байна.

Мал аж ахуйн салбарын хөгжилд тулгамдаж буй асуудал нь малын өвчлөл, мал эмнэлгийн үйлчилгээний үнэ тарифын асуудал байдаг. Олон улсын хорио цээртэй мал, амьтны гоц халдварт өвчний тархалтаас үүдэлтэйгээр мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гадаад зах зээлийн нөхцөлд хязгаарлагддаг.

Манай яам малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин тарилгын хөлсийг 2023 онд нэг дахин нэмэгдүүлсэн. Ингэснээр малын вакцин тарилга зэрэг мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, мал өвчлөлийг бууруулах эерэг үр дүн нөлөө үзүүлэх болно.

Мал аж ахуйн салбарын бодлогын үр дүнг тооны бус чанарын шалгуураар хэмжих зорилтыг хэрэгжүүлж, байна. Засгийн газрын шийдвэрээр баруун 3 аймаг, Баян-Өлгий, Увс, Ховд бүхэлдээ, Хөвсгөл аймаг бүтнээр нь, Булган, Дорнод, Хэнтий аймгийн зарим сумдад мал эмнэлгийн дэглэм бүхий тусгаарлагдсан эрүүл бүс байгуулахаар бэлтгэл хангаж байна. Харин бусад аймгуудад мал бордож бэлтгэн нийлүүлэх хязгаарлалттай аж ахуйнуудыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад тулгуурлан байгуулах боломж бүрдүүлэх хөдөө аж ахуйн бүсийн тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулан Улсын Их хуралд өргөн барих бариад байгаа болно.

Тусгаарлагдсан эрүүл бүс байгуулах, хамгаалалттай аж ахуй байгуулахтай холбогдуулан Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд мөн шаардлагатай өөрчлөлт оруулахаар санал тусгаж байгаа болно. Эдгээр эрүүл бүсэд тусгаарлагдсан аж ахуйнуудад бордох мал сүргийг олон улсын шаардлагын дагуу ялган тэмдэглэж, бүртгэлжүүлсэн түүхий эд, бүтээгдэхүүнийг мөшигөх тогтолцоог бүрдүүлэх замаар гадаадад гарах үнийг нэмэгдүүлэх арга хэмжээг мөн хэрэгжүүлэх юм.

Ийнхүү Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж шаардлагыг хангасан малын өвчнөөр тайван бүс байгууламжийг бий болгосноор мал аж ахуйн салбараас үйлдвэрлэх түүхий эд болон боловсруулсан бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, гадаадын зах зээлээс валютаар орлого бүрдүүлэн салбарын хөгжилд төдийгүй малчид, иргэдэд ААН-

үүдийг ашигтай ажиллах эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх болно.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны Хүнсний хангамж хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай 63 дугаар тогтоолын хүрээнд дээрх ААН-үүд мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих, эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын зээлд хамрагдаж байна. Тухайлбал, мах, сүү, тахианы мах, өндөг үйлдвэрлэлийн чиглэлээр 12 иргэн ААН 29,7 тэрбум төгрөгийн зээлд хамрагдсан ба одоо үйлдвэрлэлээ өргөтгөх ажлыг хийж байна.

Малчдын залуу халааг бэлтгэж, дэмжих талаар төрөөс тодорхой бодлого арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Монгол Улсын Их Хурлаас Малын генетик нөөцийн тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд малчдын эрх, үүргийг шинээр тодорхойлсон. Өөрөөр хэлбэл Хөдөлмөрийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд туслах малчинтай байгуулах хөдөлмөрийн гэрээний онцлогийг тодорхой тусгаж, цалингийн доод хэмжээтэй тэнцүү буюу түүнээс их хэмжээгээр сар бүр цалинжуулж ажиллуулах боломж бүрдүүлсэн.

22 оны жилийн эцсийн байдлаар 19 мянга орчим туслах малчин, ажил олгогч, малчинтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газар 2020 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол малчин” үндэсний хөтөлбөр нь төрийн зүгээс малчдад тулгамдсан зарим асуудлыг шийдвэрлэх, малчдыг мэдээллээр хангах, хөгжүүлэх, орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, бүтээмж, орлого ашгийг нь өсөхөд чиглэгдсэн хөтөлбөр болсон хэдий ч уг хөтөлбөрт тусгагдсан хөрөнгө

санхүүжилтийн асуудал бүрэн шийдэгдээгүй байгаатай холбоотой зарим хүндрэл үүсэж байгааг тэмдэглэж байна. Тиймээс НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын дэмжлэгтэйгээр залуу малчдын сургалтын хэрэгцээг тодорхойлох нь төслийг 2021-23 онд хэрэгжүүллээ. Төслийн үр дүнд залуу малчдад зориулсан чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулаад байна. Цаашид энэхүү хөтөлбөрийг манай салбарт хэрэгжих олон улсын төсөл хөтөлбөрөөр дамжуулан малчдад зааж сургах үр дүнд нь хүрэх чиглэлээр ажиллах болно.

Өнгөрсөн 7 хоногт Мал аж ахуйн сэргэлт Залуу малчдын үндэсний чуулган Төрийн ордонд зохион байгуулан малчдад тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр 10 арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэ хямд өртөг шингэсэн бүтээгдэхүүн болон боловсруулагдаж чадахгүй байгаа нь үнэний талтай. Бид арьс шир, ноос ноолуурын боловсруулалтыг сайжруулах чиглэлээр дараах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа.

Тухайлбал арьс ширний боловсруулах үйлдвэрийг дотооддоо барьж байгуулан ашиглалтад оруулах хүртэл хугацаанд арьс ширнийг түүхийгээр нь гадаадад гаргах боломжийг бүрдүүллээ. 2025 он хүртэл. Мөн ноолуурын боловсруулалтын шаталтыг ахиулж, угаасан бус самнасан ноолуур экспортлох зохицуулалтын арга хэмжээ авлаа. Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан эрүүл мэндээ хамгаалж эдийн засгаа сэргээх 10 их наяд цогц төлөвлөгөөний хүрээнд ноолуур бэлтгэлийн үйл ажиллагаанд 217 тэрбум, арьс шир бэлтгэлийн үйл ажиллагаанд 20 тэрбум, ноос бэлтгэлд 16 тэрбум төгрөгийн нэн хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкуудаар

дамжуулан олгосон бөгөөд Засгийн газраас нийт зээлийн хүүгийн хөнгөлөлтийг олгосон.

Зээл зээлийн хүүгийн зөрөө зэрэг татаас урамшууллын бодлогоос гадна мал махны экспортыг дэмжих бодлого баримтлан зарим шийдвэрийг гаргаад байна. Тухайлбал Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн зөвлөмжөөр адуу, хонь, ямаа, түүхий мах боловсруулах мах үйлдвэрлэлийн гараар боловсруулсан үхэр, хонь, ямааны махыг бодлогын хүрээнд үндсэн дээр хязгаарлалтгүй квотгүйгээр экспортлохоор баталсан. Ингэснээр экспортлогч, импортлогч талууд талын хооронд байгуулсан Мал эмнэлгийн хорио цээрийн протокол болон импортлогчийн шаардлага хангасан тохиолдолд тэмээнийхээс бусад бүх төрлийн малын түүхий болон дулааны аргаар боловсруулсан махыг экспортолж, малыг эдийн засгийн эргэлтэд эрчимтэй оруулах боломжийг бүрдүүлсэн юм.

Мөн Засгийн газраас 2017 оны 318 дугаар тогтоолоор үржлийн бус эр хонь, ямааны 10 хүртэл хувийг экспортлох ажлыг зохион байгуулж байна. Түүнчлэн мал махны экспортын улирлын ялгааг арилгаж, нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг хангах зорилгоор Засгийн газрын 22 оны 424 дүгээр тогтоолоор мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүсүүдийг байгуулахаар шийдвэрлэн, холбогдох анхан шатын арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна.

Ингэснээр жил бүр 25-30 сая малыг эдийн засгийн эргэлтэд оруулж, бэлчээрийн ачааллыг бууруулах, малчид, аж ахуй эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэн, дотоодын ажлын байрыг шинээр бий болгох боломж бүрдэх юм.

Хот, суурин газрын хүн амын сүүний хангамжийг сайжруулах зорилгоор өвлийн улиралд бэлтгэн нийлүүлсэн нэг литр сүүнд 500 төгрөгийн урамшуулал олгож эхэлснээр сүүний нийлүүлэлтийн хэмжээ сүүлийн 3 жилд 52

хувиар нэмэгдсэн юм. Энэ жилээс 24 оноос бэлтгэх үнийн хэмжээг дахин нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах чиглэлээр сүүний урамшууллыг 2 дахин нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажилласан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Уур амьсгалын өөрчлөлт дасан зохицсон ухаалаг мал аж ахуйг хөгжүүлэх бодлогын болон зохион байгуулалтын арга хэмжээг Олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж, байгаль, бэлчээр болон усны нөөцөд уур амьсгалын өөрчлөлтөд хэрхэн нөлөөлж буй талаар малчдыг зохих мэдлэг мэдээлэлдээ харцуу арга хэмжээ авах чадвартай болгох чиглэлээр Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь төслийн уур амьсгалын өөрчлөлт хамгийн эмзэг байгалийн нөөцөөс хамааралтай Ховд, Завхан, Сүхбаатар, Дорнод аймагт хэрэгжүүлж эхлээд байна. Энэ ташрамд Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн үндэс болсон бэлчээрийн бүртгэл, үнэлгээг дахин нарийвчлан хийж, бэлчээрийн төрөл төлөв байдлыг бодитой тодорхойлох, хөдөө аж ахуйн цаг уурын мэдээллийг өргөтгөх, мэдээлэл нь салбарын эрсдэлийг бууруулах арга хэмжээ төлөвлөх хэрэгжлийг хангах ач холбогдолтой болохыг тэмдэглэж байна.

Манай улсын мал сүргийн тооны өсөлтөөс шалтгаалсан бэлчээрийн даац хэтрэлт төвийн бүсийн аймгууд их байгаа. Бэлчээрийн даацад тохирсон тооны малтай, аж ахуйтай байх бодлогын хүрээнд малын борлуулалтыг дэмжих, махны үйлдвэрлэл нэмэгдүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх шаардлага нэн тэргүүний зорилт болж байна.

Манай яам жил бүрийн бэлчээрийн даацын судалгаанд үндэслэн мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангаж отор нүүдлийн зохицуулалтыг хийж байгаа болно. Улсын

тусгай хэрэгцээний нутаг буюу аймаг дундын отрын 9 бүсэд 783 мянган га бэлчээрт 23-24 онд өвөлжүүлж, хаваржуулах малын тоог тодорхойлох, орон тооны бус зөвлөлийн хурлууд эдгээр өдрүүдэд зохион байгуулагдаж байна.

Хөдөө аж ахуйн салбарын 23-24 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан тухай нэгдсэн дүнг 11 дүгээр сарын 20-ны дотор Засгийн газарт танилцуулах бэлтгэл ажлыг хангаж байна.

Бэлчээрийн даац хэтэрсэн, бэлчээр доройтсонтой холбоотой болон малын үржлийн ажил үйлчилгээ мал үржлийн ажилд био технологийн ололт нэвтрүүлэх “шинэ хөдөө” хөтөлбөртэй холбоотой бусад мэдээллийг та бүхэн танилцуулгаар хүргүүлсэн болно. Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Хаянгаагийн Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуй, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Гэлэгжамцын Наранчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын хяналтын газрын дарга Бямбадоржийн Санчирдорж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Даваагийн Довчинсүрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Аюушжавын Нарантуяа.

Асуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд бүртгүүлнэ үү. Дашдондогийн Ганбат гишүүнээр тасаллаа. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуулт асууна.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Өнөөдөр бас цаг үеийн чухал асуудал байна. Энэ малчдын өмнө тулгамдаж

байгаа асуудал гээд. Тэгэхээр манай малчдын өмнө тулгамдаж байгаа их олон асуудал бий л дээ. Тэгээд би ХАА, хүнс хөнгөн хүнсний үйлдвэрийн сайдаас нэг 3, 4 зүйлийг тодруулъя гэж бодож байна.

Тэгэхээр хөдөө аж ахуйн салбарт тулгамдаж байгаа маш олон асуудал бий, маш олон асуудал бий. Хамгийн том асуудал нь энэ бэлчээрийн асуудал байгаа юм. Бид чинь мал аж ахуйгаа яаж хөгжүүлэх вэ, тоо толгойгоо яаж нэмэгдүүлэх вэ, эрүүл мэндийг нь яаж сайжруулах вэ гэж яриад байдаг. Юу идүүлэх вэ, идэх вэ гэдгийг нь ярьдаггүй. Сүүлийн үед нийт, сүүлийн 10 жилийн байдлаар Монгол Улсын нийт бэлчээрийн нөгөө 110 сая га бэлчээрийн минь нэг бараг 70 орчим хувь нь их бага хэмжээгээр цөлжсөн байна гэж байгаа юм. Гэтэл бид нар бэлчээрийн тухай огт ярихгүй байгаа юм.

Тэгээд 1 дүгээрт нь, би энэ бодлогын яам Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бэлчээрийн талаар ямар бодлого чиглэл гаргаж, юу хэрэгжүүлэхээр бэлтгэж байгаа юм бэ гэдгийг 1 дүгээрт нь асууя гэж бодож байгаа юм.

2 дугаарт нь, малчдын талаар авах 2 дахь том арга хэмжээ энэ залуу малчдын тухай асуудал байгаа юм. Манай энэ боловсролын тогтолцоотой ч бас энэ холбоотой юм байгаа юм. 12 дугаар анги төгсчихсөн хүүхдийг малчин болгоно гэж үндсэндээ байхгүй байгаа юм. Би зүгээр өөрийнхөө аймгийн хэмжээнд Өвөрхангай аймгийн хэмжээнд л үзэхэд сүүлийн 5 жилийн хугацаанд мал аж ахуйн салбар дээр гарсан 12 дугаар анги төгсөөд гарсан хүүхэд хэд байна вэ гэхээр бараг 10 хуруунд нь багтахаар байгаа байхгүй юу. Малчны хүүхэд л малчин болно шүү дээ. Тийм учраас энэ би боддог юм. Энэ ахлах ангиас нь энэ мал аж ахуйн салбарт ажиллах хүүхдүүдэд энэ мал аж ахуйн чиглэлийн хичээл заах тэр чиглэлийн юмнууд руу орох ёстой байхгүй юу. Ингэж байж бид нар энэ залуу малчдыг бэлтгэх ёстой. Энэ чиглэлээр Хүнс, хөдөө

аж ахуйн яам, Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтарч байгаа юм байна уу. Яг энэ залуу малчдыг бэлтгэх чиглэлээр бодож байгаа гэдэг асуудал байгаа юм.

3 дахь асуудал, малчдыг бас энэ бүлгээр ажиллах, хоршоо болгох, хөрөнгө хөдөлмөрөө хорших асуудал чухал байгаа юм. Энэ чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, нөгөө цаг бага байгаа учраас би хурдан явахгүй болохгүй болчхоод байгаа юм.

4 дүгээрт нь, түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай асуудал байгаа юм. Энд хамгийн чухал юм нь үйлдвэрлэл. Энэ үйлдвэрлэлүүдийг дэмжих тухай асуудал байгаа. Бүс нутгийн хэмжээнд үйлдвэрүүдийг бий болгож, тэдгээрийг дэмжих асуудал хэрэгтэй байгаа юм. Энэ 2023 онд мал аж ахуйн түүхий эдэд түшиглэсэн үйлдвэрүүдийг дэмжих чиглэлээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд болон энэ банкны зээлийн хүүг нэмэгдүүлэх чиглэлээр тусгагдаж байгаа ямар асуудал байна вэ гэдгийг би 4 дүгээрт нь асуух гээд байгаа юм.

5 дугаарт нь, энэ салбар дээр тулгамдаж байгаа юм бол энэ туслах малчдын тухай асуудал байгаа юм. Үүнийг хэн ч авч үздэггүй. Тэгээд энэ туслах малчдын эрх зүйн орчныг бий болгох асуудал байгаа юм. Тэгэхгүй бол эдгээр маань нөгөө эрх зүйн орчин нь тодорхой бус учраас энэ туслах малчдын асуудал нэг хаягдаад байдаг.

Дараагийн асуудал бол манай энэ хөдөө аж ахуйн салбар бол хамгийн олон ажлын байр бий болгох том салбар аа. Хөдөө аж ахуйн салбарын энэ ажлыг, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх асуудал байгаа юм. Малчдын бүх хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх асуудал. Ингэж байж хөдөө аж ахуйн салбар дээр олон ажлын байр бий болгох, энэ чиглэлээр хийж хэрэгжүүлэхээр бэлтгэж байгаа асуудал гэсэн 5, 6 багц асуудал ... /минут дуусав/

Г.Занданишатар: Хаянгаагийн Болорчулуун сайд хариулна.

Х.Болорчулуун: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Тогтохсүрэн гишүүн бэлчээрийн талаар маш анхаарал тавьж бас ажигладаг. Ялангуяа энэ төвийн бүсүүд, баруун, урд чиглэлийн аймгууд, баруун аймгууд бас бэлчээрийн даац нь үнэхээр их нэрвэгдсэн. Байгалийн хадлангаа авч чадахаа больсон. Тийм учраас аймгаас аймаг дамжин отор нүүдэл хийдэг болсон. Зүүн аймгуудаас хадлан тэжээлээ авдаг болсон. Ялангуяа өнгөрсөн жилийн цаг агаарын зудын хүндрэлтэй байдал бүр их малчдад, орон нутгийн удирдлагуудад бүх л дээр дооргүй ойлголтыг өгсөн, хатуу сануулга өгсөн. Тийм учраас зөвхөн бэлчээрээр нүүдлийн мал аж ахуйг ингээд явуулаад байх биш ээ. Бас хагас бэлчээрийн хүндрэлтэй үед өвс ногоон тэжээлээр хангадаг байхаар бас яам бодлогын хэмжээнд бас ажиглаж байгаа. Энэ жил 100 мянган га-д ногоон тэжээл тарьсан. Тарьсан нь өнгөрсөн жилийнхээс 42 хувиар өссөн. Энэ жил 225 мянган тонн ногоон тэжээл хурааж авна. Энэ өвлийг өнтэй давахад тодорхой хэмжээнд үр дүн өгнө.

Мөн өвсний асуудлыг бас гадагшаа өвс экспортлохгүй. Зөвхөн дотооддоо өвсийг худалдан борлуулах ажлыг бас зохион байгуулаад байгаа гэдгийг бас хэлье.

Түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар анхаарч ажиглах ёстой гэж байна. Засгийн газар өнгөрсөн намар 22 оны 10 сарын 19-ний өдөр Засгийн газрын тогтоол гарсан. 13 оноос арьс ширийг гадагшаа гаргахыг экспортыг зогсоосон байсан. Энэ явдлыг чөлөөлж, 2 жилийн хугацаатай арьс ширний үйлдвэр ашиглалтад ортол бүх төрлийн арьс ширийг экспортод чөлөөтэй гарах ийм Засгийн газрын тогтоол гарсан байгаа. Энэ намраас арьс ширний үнэд тодорхой өөрчлөлт нэмэгдэл орно гэж тооцож байгаа.

Мөн арьс шир худалдан авах үйлдвэрүүдэд бодлогын зээлийн хүүгийн дэмжлэг бүхий зээл хөнгөлөлттэй зээл олгоно, энэ намраас гэдгийг бас хэлье.

5-д нь, туслах малчны талаар асуулаа. Хөдөлмөрийн тухай хуулийн 71 дүгээр зүйл туслах малчинтай байгуулах хөдөлмөрийн гэрээний онцлогийг тодорхой тусгаж оруулж, цалингийн доод хэмжээтэй тэнцүү буюу түүнээс их хэмжээгээр сар бүр цалинжуулж ажиглуулах боломжийг бүрдүүлсэн байгаа. Ингэснээр 22 оны жилийн эцсийн байдлаар 19 мянга орчим туслах малчин, ажил олгогч, малчинтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиглаж байгаа статистик тоо тооцоолол гарч байгаа болно. Таны хэлдгээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар энэ манай яамны харьяа салбар үнэхээр бас уул уурхайтай адилхан овоож оцойтол их татвар төлөөд байдаггүй ч гэсэн нийгмийн ачааллыг нуруун дээрээ авч явдаг салбар аа. Зөвхөн энэ салбарт нийт Монгол Улсын ажиглах боловсон хүчний 50 хувь нь хамрагдаж байна. Тийм болохоор нийгмийн салбар гэж хэлж болно гэдгийг бас хэлье.

Зарим нь бас саналаар ингээд хэлчих шиг боллоо. Баярлалаа.

Г.Занданишатар: Хэн хариулах вэ? Нэмж хариулах юм уу? Содномын Чинзориг гишүүн асуулт асууна.

С.Чинзориг: Үгүй ээ, үгүй, энэ чинь Засгийн газрын шийдвэр биш гишүүний асуултад хариулж байгаа юм шиг асууна шүү дээ. Орон нутгаас сонгогдсон гишүүн. 2, 3 асуулт байгаа юм. Би байнга л ярьдаг л даа. Ер нь энэ мал аж ахуйн талаар Төрөөс баримтлах бодлогоо нэг шинэчлэх цаг болсон юм биш үү, Болорчулуун аа. Би байнга л яриад байгаа юм. Энэ мал аж ахуй чинь нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг манай орон. Байгалиасаа цаг уураасаа хэт их хамааралтай. Байгаль цаг агаар сайхан бол манай малчид нутаг орондоо нэг тав тухтай өвөлжиж, хаварждаг. Байгаль

цаг агаар хатуурхлахаар тэгээд л хүний нутаг руу алсын отор хийгээд л хөөгдөн туугдаад л явдаг. Одоо бидний уламжлалт энэ арга барил ярьдаг манай ард түмэн ч ярьдаг, хаяа багтвал бууж, хамар хатгавал иднэ гэдэг энэ зарчмаар чинь энэ мал аж ахуйн бодлого ч явах боломжгүй болчихлоо шүү дээ, Болорчулуун сайд аа.

Тэгэхээр энэ мал аж ахуйн талаа талаар төрөөс баримтлах бодлогоо шинэчлэх талаар юу хийж байна вэ? Ер нь мал аж ахуйн талаар баримтлах бодлогыг шинэчлэлийн асуудлыг та бүхэн бас юу гэж бас тодорхойлж томъёолж байгаа вэ гэдэг нэг асуулт байгаа юм.

2 дугаарт, бид нар энэ мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг тогтвортой үнэтэй байлгана, үнэтэй болгоно, малчдын орлогыг дэмжинэ гээд маш олон жил ярьж байгаа юм. Тэгэхээр энэ талаар тийм тодорхой дорвитой үр дүн гарахгүй л байна л даа. Аль л Жасрай гуайн Засгийн газрын үед л энэ ноолуурыг түүхийгээр нь гаргана, гаргахгүй гээд л бөөн хэрүүлтэй байж байсан. Яг энэ яг хэвээрээ. Тэгэхээр энэ мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг үнэтэй болгох, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болгох, улмаар малчдын орлогыг тогтвортой болгох талаар тийм дорвитой ямар бодлого байх барьж барих вэ гэдэг асуудал.

3 дахь асуудал нь. Ер нь малчдын хөдөлмөр чинь амаргүй, хүнд хөдөлмөр. Биеийн хүчний зарцуулалт хамгийн өндөртэй хөдөлмөр шүү дээ. Малчдын хөдөлмөр. Хадлан хадсан ч дандаа биеийн хүчний хөдөлмөр зарцуулна. Худгаасаа ус татсан ч л дандаа биеийн хүчний хөдөлмөр зарцуулна. Тэгэхээр малчдын хөдөлмөрийг бас хөнгөвчлөх чиглэлээр малчдын энэ биеийн хүчний хөдөлмөр зарцуулалтыг багасгах чиглэлээр танай яам ямар бодлого баримталчих юм бэ? Жаахан тийм механикжуулах тийм ямар бодлого байна вэ гэж.

4 дэх асуудал нь, одоо ажиллаж байгаа энэ үйлдвэр, аж ахуйн байгууллагууд дээр ямар дэмжлэг үзүүлэх вэ? Тухайлбал манай Өвөрхангай аймаг махны үйлдвэртэй, арьс ширний үйлдвэртэй, ноос боловсруулах үйлдвэртэй. Сая Ерөнхий сайд орон нутагт ажиллахдаа гурвуулан дээр нь үзсэн. Маш үлгэр жишээ ажиллаж байгаа юм байна л гэж ярьсан. Тэгээд энэ хүрээнд 2, 3 юм шийдэж өгөөч гээд байгаа юм.

Нэг дэх асуудал нь эдгээр үйлдвэрүүдэд урт хугацаатай хүү багатай зээлийн дэмжлэг хэрэгтэй байна. Үүнийг яаж дэмжлэг үзүүлэх вэ?

Өчигдрийн Засгийн газрын хурал дээр чинь Ерөнхий сайд үүнийг Өвөрхангай аймагт ажиллахдаа анхааруулсан үүнийг анхаарч шийдээрэй гээд л танд бас үүрэг болгосон.

2 дахь асуудлууд нь энэ үйлдвэрүүд дээр итгэмжлэгдсэн лабораторитой болох шаардлагатай байгаа юм. Үүнийг нь ч гэсэн Ерөнхий сайд шийдэж өгье гэж хэлсэн. Тэгээд энэ чиглэлээр ямар бодитой ямар дэмжлэг байна вэ?

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Чинзориг гишүүнийхээ хувьд асууж байх шиг байна. Засгийн газрын гишүүн маань. Гишүүний асуултад хариулъя. Мал аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлогыг өөрчлөх цаг нь болсон. Энэ аргагүй ээ, малын тоотой холбоотой. Мөн дэлхийн цаг уур өөрчлөгдөж, дулаарал болж, өвс ургамлын гарц багассантай холбоотой зайлиггүй өөрчлөх цаг нь болсон, өөрчлөх бодлого явагдаж байгаа гэж бас хэлье. Үнэхээр таны хэлдгээр бэлчээрээр мал 100 хувь онд орох баталгаа байхгүй болчихоод байна. Ялангуяа төв болон баруун аймгуудад. Тэгэхээр энэ дээр хагас бэлчээрийн мал аж ахуй эрхлэх бас тооноос чанарт шилжих ийм ажил зайлиггүй хийгдэхийг энэ байгаль цаг уур

бас хатуу сануулж байна. Энэ дээр тантай бас санал нэг байна.

Тийм ч учраас энэ жил гэхэд ногоон тэжээл тариалалт өнгөрсөн жилийнхээс 42 хувиар өссөн, 225 мянган тонн ногоон тэжээл хураа авах ерөнхий урьдчилсан баланс гарсан.

Мөн гадагшаа өвс экспортолдог байсан. Энэ экспортлох байдлыг хаасан, зөвхөн дотооддоо Монголдоо өвс борлогдох ийм нөхцөлийг бүрдүүлсэн.

Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг үнэ цэнтэй болох ямар арга хэмжээ авч байна аа гэж байна. Би энэ дээр ноолуур, сүү, мах болгон дээр хэлье.

Ноолуур гэхэд манай Монгол Улс чинь дэлхийн ноолуурын 45 хувийг дангаараа гаргадаг. Тийм мөртөө үндсэндээ түүхийгээр нь угаасан байдлаар гээд л экспортлоод л байсан. Үүн дээр нэг 400 сая орчим долларыг гаднаас юу, валют олдог. Засгийн газрын тогтоол гарч 24 оны 07 сарын 01-нээс зөвхөн самнасан ноолуур экспортод гаргахаар техникийн зохицуулалтаар шийдвэрлэсэн. Ингэснээр 46 доллароор гаргадаг угаасан ноолуур 96 доллароор килограмм нь самнасан ноолуур болж үнэ цэн нь өснө. Ингэснээр 400 сая доллар олдог байсан бол 700 сая долларыг ноолуураас олох боломжтой. Цаашилаад бид нар ээрэх утас, бэлэн хувцас гээд явбал бүр миллиард 500 сая доллар олох боломжтой гэдгийг бас хэлье.

Тэгэхээр ноолуурыг үнэ цэнтэй байлгахын тулд шаталсан аргаар үйлдвэрлэлийн шатлалыг нэмэгдүүлэх байдлаар ноолуураас олох мөнгөн урсгалыг нэмэгдүүлнэ гэдгийг бас хэлэх байна.

Сүүн дээр. Сүү бас манай улс зундаа нэг 60-70 хувь дотоодын хэрэгцээ хангаад, өвөлдөө ердөө гучхан хувийг шингэн сүүгээр хангаж байгаа юм. 5,5 сая

үхэртэй мөртөө ийм бага хэмжээгээр хангаж байна.

Харин сүүлийн 3 жилд сүүний урамшууллыг олон улсын жишигээр олгодог болсон. 500 төгрөг 1 литр тутамд. Ингэснээр сүүний үйлдвэрлэл 3 жилийн дунджаар тэр 3 жилийн өмнөхөөс 52 хувиар өссөн. 14 хоногийн өмнө Засгийн газрын хурлаар сүүний 500 төгрөгийн урамшууллыг 1000 төгрөг болгохоор шийдвэрлэсэн нь сүүний үйлдвэрлэлийг эрс нэмэгдүүлэхэд бас нөлөөлөх болно гэдгийг бас хэлэх байна аа.

Мах, махан дээр манай яам чөлөөтэй, ямар ч квотгүй экспортод гарах малын махан дээр ийм бодлогыг явуулж эхлээд байна. Өнгөрсөн жил үхрээс бусад дээр нь квотыг чөлөөлсөн бол энэ жил бас 7 хоногийн өмнө үхрийн квотыг бас байхгүй болголоо, махны. Өнгөрсөн жил 16 мянган тонн мах экспортод гарсан бол энэ онд 10 сарын 01-ний байдлаар 53 мянган тонн мах гараад байна. Энэ байдлаараа Монгол Улсын түүхэнд 18 онд хамгийн их буюу 70 мянган тонн мах экспортод гарсан. Энэ рекордыг бас эвдэж магадгүй. Ийм шинжтэй махны экспорт явагдаж байгаа. Гэхдээ бид нар махны экспортыг ялангуяа үхрийн махан дээр чанах байдлаар урагшаа гаргаж байгаа. Өөрөө үхрийн мах чинь их паразит шимэгч агуулдаг гэж үздэг, өөрөө хивэгч амьтан болохоор. Цаашидаа олон улсын жишигээр үнэ цэнтэй мах экспортлохын тулд тусгаарлагдсан аж ахуй байгуулж экспортод гаргах, эрүүл бүс байгуулж экспортод гаргах ийм ажлыг хийх ёстой. Засгийн газрын тогтоол ч гарсан. Энэ нам ... /минут дуусав/

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Тувааны урилгаар Төв аймгийн Бүрэн сумын ЕБС-ийн 1990 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Ингээд 90 оны төгсөгчдөдөө эргэн дурсахуйн уулзалтад нь амжилт хүсээд, сайн сайхныг хүсэн ерөөе.

Энэ 2 асуултынх нь хариултыг Болорчулуун гишүүн, энэ ажлын хэсэг албан бичиг энэ тэрээр өгөөд Засгийн газар дээрээ ярилцацгаа. Ерөнхий сайдынхаа өгсөн үүрэг даалгаврыг Засгийн газар дээрээ ярьцгаа, энд ярихгүй.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Б.Бат-Эрдэнэ: Би гишүүнийхээ хувьд асуулт асуугаад байна шүү, Болорчулуун сайд аа. Тэгэхээр ийм юм, яах вэ зүгээр эндээс ярихаасаа илүү бас бодит газар дээр нь очиж үзээд, энэ сайн туршилагыг энэ төрийн бодлогод тусгах талаар санал тавьдаг. Түүний зэрэгцээгээр бас яг анхан шатаас нь ажлыг хэрэгжүүлээд эхлэх юм сан гэж ингэж санаа тавьдаг ийм хүн байгаа юм. Тухайлах юм бол 2005 онд энэ Монгол Улсын үйлдвэржилтийн түвшнийг сайжруулах чиглэлээр санал тавьж байсан. Өвөрмонголын өөртөө засах орон, Ордос энд уул уурхайн бүтээгдэхүүнийг яаж эцсийн үйлдвэрлэл өртөг нэмэгдүүлж, яаж бүтээгдэхүүн гаргаж байгаа талаар санал тавьж байсан. Ингээд энэ Монгол Улсын төрийн бодлогод Монголын ард түмэнд хэрэг тус болуужин гэсэн ийм шинэ санаа, ийм сайн туршилагыг би хаана явсан газраасаа олж, бичиж тэмдэглэж, аян замын тэмдэглэл бичиж, нийтэд хүргэж явж ирдэг ийм хүн л дээ. Тухайлах юм бол Болорчулуун сайд бид Латин Америкийн хөдөө аж ахуй, тэр тусмаа мал аж ахуй хөгжсөн 3 орноор явж энэ сайн туршилага жишигийг тухайн үед олон нийтэд хүргэж, хэвлэлд бичиж, ном товхимол болгож, төрийн бодлогод тусгуулахын төлөө санаачилж явсан. Энэ цагаас хойш 2014 он гэхэд чинь 10 жил болчихож. Энэ бид нарын дэвшүүлсэн саналыг Монголын төр бодлого болгоод хэрэгжүүлсэн бол энэ хөдөө аж ахуй тэр тусмаа мал аж ахуйн салбарт шал өөр эргэлт гарахаар байсан. Тэр 3 орон гурвуулаа 1 зүйлийг л хэлж байгаа юм. 16 мянган км бид нар усан тээврээр Хятад гэж том зах зээлд нийлүүлдэг болсон. Энд малын амьсгаанаас бусдыг бүгдийг нь гаргаж байна. Алт болгож байна, валют

болгож байна гэсэн. Тэгээд энэ сайн туршилага, жишигийг хэлээд хэлээд үнэхээр хүлээж авч ажил болгосонгүй л дээ. Тэгээд энэ талаар ямар үр дүн гарч байна гэж?

Нөгөө нэг хэлэх юм бол энэ нүүдлийн ахуй соёл дээрээ тулгуурласан энэ Монгол орныхоо тусгаар тогтнолын баталгаа болж байгаа малчин түмнийхээ энэ залуу халааг бэлтгэх чиглэл дээр анхаарах хэрэгтэй. Бас ялгаа байхгүй одоо Дорнодын талд физикийн том доктор Лхагваа гуайн хүү Лхагвасүрэн гэр бүлийнхээ хамт байгуулсан багийн бага сургууль гэж байгаа шүү дээ. Би үүнийг мөн ч олон удаа хэлж байгаа. Тэгээд энэ талаар ерөөсөө ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд хариулна.

Х.Болорчулуун: Бат-Эрдэнэ гишүүнийхээ асуултад хариулъя. Гаднын улс орны туршилагыг бишгүй судалсан, үүний мөрөөр ямар арга хэмжээ авч байна вэ? Хөдөө аж ахуйн яам гэж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг гэж асууж байна. Үнэхээр 2015 онд Бат-Эрдэнэ гишүүн болон бас манай парламентын 5, 6 гишүүн Латин Америкт Уругвай, Аргентин, Бразилд энэ мал аж ахуйн талаар туршилага судалсан. Тэндээс бид нар мал аж ахуйгаа яаж хөгжүүлдэг юм, яаж экспортод махаа гаргадаг юм, үнэтэй гаргадаг юм гэдэг л ойлголтыг маш сайн авсан. Жишээлбэл Уругвай улс манайхаас сая гаруйхан хүн ам илүү. 5 сая хүнтэй. Тэгсэн мөртөө 13 сая үхэртэй, 13 сая үхрээ бүгдийг нь бүртгэл хяналтад оруулсан. Өөрөөр хэлбэл ээмэгжүүлсэн. Ингээд үхрээ бүгдийг нь эрүүл эсэхийг нь баталгаатай болгосон. Иймээс үхрийн махаа мөн амьд үхрээ саяын Бат-Эрдэнэ гишүүний аваргын хэлдгээр Хятад хүртэл 16 мянган км-ийн цаанаас далаа давуулаад үнэ цэнтэйгээр экспортод гаргаж чадаж байна. Тэр жишжиг хүн амтай, тавхан сая хүн амтай улс мөртөө экспортлогч том 5

улсын нэг болсон. Бид тэгэхэд зүгээр бэлчээрээ явуулж байгаад экспортолно гэсэн ойлголттой л саяхан хүртэл байлаа шүү дээ.

Тэгэхээр энэ байдлыг өөрчилж, Монгол Улсын Малын генетик нөөц нөөцийн тухай хууль, мөн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль гарсан. Монгол малаа бүртгэл хяналтад оруулах, ялангуяа үхэр сүргээ бүртгэл хяналтад оруулахад ажлыг хийж эхлээд байна. Ирэх нь хавар ялангуяа эрүүл бүсүүд дээр мал эмнэлгийн дэглэм бүхий эрүүл бүс бүхий аймгууд дээр үхэр сүргээ бүрэн бүртгэл хяналтад оруулна. Тэгж байж бид нар бусдын жишгээр махаа үнэтэй гадагшаа гарах боломж бүрдэнэ гэдгийг хэлье.

Бас Хөдөө аж ахуйн бүсийн тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг бас шинэчлэн энэ намрын чуулганаар оруулахаар хэлэлцэхээр оруулаад байгаа гэдгийг бас хэлье.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангахад анхаарах ёстой олон зүйлүүд байгаад байх шиг байна.

1 дүгээрт, бид нар энэ бэлчээрийн даац, чадамжид нийцэх тухай, энэ бэлчээрийн доройтлыг бууруулах сайжруулах тухай л асуудал байгаад байна л даа. Тийм учраас байгалийн ургамлын үр үржүүлэг, түүгээр нөхөн сэргээлт хийх асуудал руу ер нь ямар бодлого чиглэл байна вэ? Сая бид нар Өвөр Монголд очсон. Тэр Монгол өвс гэж компани бол улс орныхоо өнцөг булан бүрээс хөрснийх нь дээжийг авчраад түүнд нь зохицох ургамлынх нь үр үржүүлгийг хийгээд нөхөн сэргээлтийг нь хийгээд яваад байгаа. Ийм зүйл байгаад байна л даа. Үүнийг ер нь Монголдоо хэдүүлээ нутагшуулах чиглэлээр энэ шууд бэлэн туршилага юмнуудтай холбогдох

талаар ер нь ямар бодлого чиглэл байна вэ гэж нэг ийм зүйл байна гэж.

2 дахь зүйл. Энэ тэжээлийн ургамлын тариалалт. Ер нь тэр олон найрлагат уураг тэжээлийг түүхий эдэд урамшуулал олгохгүй юм уу? Ингэж байж бид энэ үйлдвэрийн аргаар боловсруулсан тэжээлийнхээ хэмжээг нэмэгдүүлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ер нь энэ малын тарга хүч юмнуудыг өвөл, хаврын хатуу цагт гөвчихгүй байх энэ бололцоо боломжийг бүрдүүлэх ёстой юм биш үү? Тийм учраас тэжээлийн будаа гэдэг юм уу, эрдэнэ шиш гэдэг юм уу, энэ зүйлүүд дээр ер нь урамшуулал өгөх замаар энэ үйлдвэрлэлийг дэмжих ёстой юм биш үү гэсэн нэг ийм асуулт, санал байна гэж.

3 дахь зүйл энэ. Малчдыг өвөлжөө, хаваржаан дээр ногоон тэжээл тариалдаг ажлыг ер нь үндэсний хөдөлгөөн болгож өрнүүлбэл яасан юм бэ? Хийгээд энэ улсууд бас түрүүчээсээ юм аваад байгаа шүү дээ. Тэгээд 1 хэсэг нь хийхгүй ингээд байгаад байж боломгүй л байна л даа. Үүнийг үндэсний хөдөлгөөн болгоод, үр хангалт юмнуудыг нь бий болгоод, жижиг оврын техник хэрэгслийн хангалтыг нь хийгээд ингээд явбал ер нь бололцоо байна уу? Энэ дээр ямар бодол санаа байна гэж?

Дараагийн зүйл. Мал эрүүлжүүлэлт гэж бид ярьж байгаа, хөрөнгөө ч нэмж байгаа. Гэхдээ бүрэн болж өгөхгүй байна аа. Тийм учраас био үйлдвэрийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэл дээр томоохон хөрөнгө оруулалт хийх ёстой юм биш үү? Гадна дотнын зээл тусламж яриад олон жил болж байна. Дотоодынхоо нөөц бололцоо төсвөө дайчилбал яасан юм бэ? Үүнийг Их Хурал ч анхаармаар байна, Засгийн газар ч анхаармаар байна. Энэ био үйлдвэрийг нэг өөрийнхөө хэрэгцээт вакцин, юмаа үйлдвэрлэж чаддаг хүчин чадалтай болгож шинэчлэх тухай асуудал байна. Үүнийг хийвэл яасан юм гэж.

Малчдын залуу халааг бэлтгэнэ. Энэ болж байна. Энэ мэргэжлийн

боловсролоор дамжуулж бэлтгэмээр байна. Энэ цаг үед энэ салбарыг авч явдаг арга ухааныг ч олгоё, юм ч үзүүлье, нүдийг нь ч тайлъя. Тийм учраас энэ мэргэжлийн боловсролд эчнээ сургалтыг ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Бэлчээрийн доройтлыг бууруулах, байгалийн ургамлыг үр үржүүлэх, нутагишуулах, тариалах талаар бас ямар арга хэмжээ авч байна. Яг үнэндээ энэ тал дээр яг тусгайлан байгалийн ургамлын үрийг тариалж, бэлчээрийг нэмэгдүүлэх гэсэн ийм төсөл арга хэмжээ хэрэгжихгүй байгаа. Хамгийн гол нь байгаа, ургаж байгаа ургамлаа хадлан хадахдаа ч гэсэн зөв зохистой хадуулах тал дээр зайлшгүй анхаарахгүй болохгүй болсон байна. Яагаад гэвэл төвийн болон баруун аймгуудаар өвс хадлан байхгүй, зүүн аймгуудад ингээд бүх хадлангаа зүүн 3 аймгаас авч байна. Тэгээд энэ дээр өнгөрсөн жил хадсан газраа дахиж хадах явдал ийм түгээмэл болсон. Үүний зохицуулалтыг хийх талаар орон нутагтай манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам ажиллаж байна.

Мөн гадагшаа өвс экспортлохгүй байх бодлого баримталж байгаа. Бид өвс экспортлоод ашиг олохгүй ээ. Харин байгалийн ургамлаа улам цаашидаа ургахыг нь хомсдуулах, зээр, гөрөөсний амьтны үр төлөө гаргах экологид хүртэл нөлөөлөх ийм байна лээ гэдгийг бас хэлье.

Та энэ тэжээлийн ургамлыг, олон найрлагат тэжээлийг бас урамшуулал өгөх, мөн энэ талаар бас нэлээн дэмжиж ажилламаар байна гэж байна. Бид нар урамшуулал өгөхөөсөө илүү энэ тэжээл үйлдвэрлэж байгаа ААН-үүдийг гадагшаа экспортод гаргаж байгаа, олон найрлагат тэжээл гаргаж байна, хивэг гаргаж байна. Үүнийг урьд урьд жилүүдэд экспортыг нь ердөө хаачихдаг байсан. Өвөл боллоо гээд л нэг ажил хийсэн болоод

л тэрийг нь хаачихдаг байсан. Энэ нь бол энэ чиглэлийн үйлдвэрүүд хөгжих боломжийг хааж байсан. Өнгөрсөн өвөл энэ хивэг болон олон найрлагат тэжээлийн гадагшаа гарах экспортыг хаагаагүй. Бид экспортыг хориглож болохгүй байхгүй юу. Аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагаанд тэгж дундуур нь тас цохиж оруулж болохгүй байхгүй юу. Үүний улмаас олон найрлагат тэжээл ч тэр, хивэг ч тэр борлогдохгүй олон мянган тонноор үлдсэн гашиун туршлага урьд жилүүд байгаа юм. Тийм учраас цаашидаа аливаа хивэг болон олон найрлагат тэжээлийн экспортод хориг тавьж хаахгүй ээ гэдгийг бас хэлье.

Ногоон тэжээлийг үндэсний хөдөлгөөн болгож өрнүүлээч ээ гэж. Үүнийг яам бодлогоор бодлого болгон ажиллаж байгаа. Малчид ч өөрсдөө их ойлголтыг бас өнгөрсөн өвлийн зудаас хатуу ойлголт их авсан. Сүүлийн 12 жил үндсэндээ зуд болоогүй шүү дээ. Сайхан өнтэй өвөл болж байсан. Тийм учраас энэ жил ногоон тэжээл тариалах явдал 42 хувиар өссөн. Мөн манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ирэх хавраас эхлээд 100 сумд 100 га ногоон тэжээлийн ажлыг тариалж хэрэгжүүлэхээр төлөвлөж ажиллаад байна гэдгийг бас хэлье.

Био үйлдвэрийг хөгжүүлэх дээр анхаараарай гэж байна. Манай Био комбинат бас социализмын үеийн яг барилга, тоног төхөөрөмж, уурын зуух тэгээд яг социализмын үеийнхээрээ байгаа. Техник технологийн хувьд үнэхээр хоцрогдсон. Тийм учраас бас ирэх жилээс олон улсын төсөл хөтөлбөрөөр энэ Био үйлдвэрийн, эмийн үйлдвэрт зарим шугамуудыг өөрчилж шинэчлэхээр юм ажиллаж байгаа гэж бас хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүн асуулт асууна.

Б.Баярсайхан: Ер нь ихэнх асуултауд бас давхцаж байна. Гэхдээ би

яг тодорхой 6 асуулт асуугаад эндээ бас яг тодорхой хариулт авъя.

Завхан аймгийнхаа малчидтай хийсэн уулзалтуудаас харах юм бол малчид нэг үеэ бодох юм бол чанартай тоонд биш чанарт анхааръя. Бэлчээрийг хайрлая гэдэг дээр бас ингээд юу дэмждэг болчихжээ. Тэгээд энэ дээр яг яам сая яг энэ тал дээр ажиллаж байна гэж байна. Эхний үр дүн яг юу юм бэ? Үр дүн гарч байна уу? Ямар үр дүн гарч байгаа юм? Үүнийг асууя.

2 дугаарт нь, энэ Монгол Улсад 200-аад мянган орчим малчин өрх байгаа. Тэгээд малчдын залуу халаанд санаа зовж байгаа олон гишүүд сая асуулт асуулаа. Яг Болорчулуун сайдаас энэ нийт малчдын 35-аас доош насны залуучууд хэдэн хувийг нь эзэлж байгаа юм бэ? Энэ дээр та бүхэнд хийсэн судалгаа байна уу? Үнэхээр малчид зөвхөн мал малладаг хүмүүс биш энэ том газар нутгаа бас эзэн болж сахиж, давхар үүрэг ингэж хүлээж байдаг ийм хүмүүс байгаа. Тэгээд энэ мал аж ахуйн салбар ингээд эзэнгүй болох эрсдэл үнэхээр өнөөдөр нүүрлэж байна. Тэгээд энэ шилжилт хөдөлгөөн бас ямар түвшинд байгаа юм бэ гэдгийг яг тоо асууя.

Өвөл хаяанд тулсан байна. Малчдын хувьд ялангуяа Завхан аймаг шиг -50 хэм хүрч хүйтэрдэг ийм уур амьсгалтай газар нутгийн хувьд өвөлжилт байнга хүндэрч байна. Тэгээд та сая ингээд ногоон тэжээлийг ингээд тариад 100 сумд ингээд тарих ийм ажил хийж байгаа гэж байна. Тэгээд энэ өвлийн өвөлжилтийн бэлтгэл ямар байгаа юм. Ялангуяа алслагдсан манай Завхан аймагт энэ ногоон тэжээл хадлан чинь үнэхээр маш өндөр үнээр очдог. Тэгэхээр энэ дээр яам энэ жил яаж анхаарах юм бэ. Өвөлжилтийн бэлтгэл яг хангагдсан уу гэдгийг асууя.

Миний 4 дэх асуулт удаа дараа асууж байгаа энэ Дарханы арьс шир, нэхий боловсрох үйлдвэрлэл хэзээ ашиглалтад орох юм бэ? Энэ хэзээ энэ

малын арьс шир ингэж үнэгүйдэж энэ хөдөө орон нутгаар нэг ингээд үнэгүй хэвтэх юм бэ? Энэ яг хэзээ ашиглалтад орох юм. Энэ дээр надаа нэг хугацаа хэлээд өгөөч.

5 дахь асуудал бол Болорчулуун сайд хүнсний хувьсгалын хүрээнд аймгуудаар их явж байгаа. Завхан аймаг хамгийн өндөр үнэтэй гурил идэж байна гэдгээ би удаа дараа хэлж байгаа. Тэгэхээр урьд нь тэр Арцсуурь боомтоор Оросоос гурил орж ирдэг байсан юм байна лээ. Одоо бол үндэсний үйлдвэрлэлээ дэмжинэ гэхчхэн байгаа. Гэтэл үндэсний үйлдвэрлэлээ дэмжээд дэмжээд үндэсний үйлдвэрлэгчдийн гурил нь Завхан аймагт үнэтэй очоод байхаар яах ёстой юм бэ? Тэгээд манай ийм алслагдсан аймагт яг Улаанбаатар хот шиг, бусад аймаг шиг арай хямдагтар яг тэдний авч байгаа үнээр хүнс хэрэглэх ийм боломж байна уу? Та энэ дээр ямар шийдвэр гаргах гэж байгаа юм? Энэ дээр хэлээд өгөөч.

6-д нь, малын өвчлөлийн асуудал байна. Энэ өвөл шүлхийгүй байх тэр нөхцөл бүрдсэн үү.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун сайд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд хариулна.

Х.Болорчулуун: Баярсайхан гишүүн бас мал, малчдынхаа төлөө санаа тавьж, бас энэ асуулгыг гаргасан манай яаманд. Сая бас өөрөө асуулт бас нэмж асууж байна. Танд бичгээр хүргүүлсэн байгаа.

Завхан аймгийнхан малаа тоонд бас чанарт анхаарах ойлголтыг авсан гэж. Үнэхээр авахаас ч өөр аргагүй. Өнгөрсөн жилийн хатуу өвөл Завхан гэлтгүй бүх аймгуудад энэ ойлголтыг аймгийн ард иргэдэд, малчдад ойлгуулсан гэдгийг бас хэлье. Бид тооны хойноос сүүлийн 12 жил өнтэй байсан учраас малыг дураар нь бэлчээрээр нь явуулаад тооны хойноос хөөцөлдсөн. Баян хүн нэг зудад гэгчээр л болох шахсан, энэ өнгөрсөн

жил, зарим газар болсон. Тэгэхээр баталгаатай мал аж ахуй эрхлэх, чанартай мал аж ахуй эрхлэх дээр бодлого яамнаас явж байгаа. Энэ түрүүний хэлдэг эрүүл бүс, тусгаарлагдсан аж ахуй байгуулах, мөн зөвхөн бэлчээрийн өвсөндөө найдах биш ногоон тэжээл, тэжээлийн ургамал ихээр тариалах ийм бодлого хэрэгжиж байгаа. Эхний үр дүн бол энэ жил ногоон тэжээл гэхэд 225 мянган тонныг хурааж авах урьдчилсан баланс гарсан байгаа. Өөрөөр хэлбэл иргэд, ААН, байгууллагууд ногоон тэжээлийг тарих тарилтаа үлэмж их хэмжээгээр ихэссэн гэдгийг бас хэлэх байна.

35-аас доош залуучууд хэдэн хувийг эзэлж байна. Мал аж ахуй энэ тэр гэж байна. Ер нь сая өнгөрсөн 7 хоногт Мал аж ахуйн сэргэлт, залуу малчдын чуулганыг Төрийн ордонд 800 залуу малчныг цуглуулан хийсэн байгаа. Энэ дээр олон санал, санаачилга, туршилага хуваалцаж ярилцсан. Эндээс хүн болгон л бид тоонд биш цөөхөн бага малаас өндөр ашиг шим хүртэж болох боломжийг тийм амьдралдаа хэрэгжүүлсэн арга туршилагыг энэ чуулган дээр хүмүүс ярьсан. Үүнийг залуу малчид их сонирхон шохоорхож бас хүлээж авч байна лээ гэдгийг бас хэлье. Тэр 35-аас доош насны залуучуудын эзлэх хувийг Наранчулуун дарга хэлчихээрэй. Мал аж ахуй дээр.

Дарханы арьс ширний үйлдвэр хэзээ ашиглалтад орох вэ. Энэ бол Дарханы арьс ширний үйлдвэрийг бас нэг хувийн хэвшилийнхэн аваад, тэгээд Хөгжлийн банкнаас зээл аваад, тэр зээлээ бас зориулалт бусаар янз бүр ашиглаад ингээд бас яг энэ хэрэгжилт, ашиглалтад орох явдалд бас хугацааны хувьд хойш нь татсан. Гэхдээ засгийн бодлого ч тэр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нэг арьс ширний үйлдвэр барьж барьж өгөхгүй. Харин дэд бүтцийг нь, тэр цэвэрлэх байгууламжийг нь барьж өгнө. Олон улсад ч тэгдэг юм байна. Бид нар нэгэнт социализм биш зах зээлд шилжчихээд үйлдвэр үнэтэй төслөөр барьчхаад дараа нь яаж хувьчилна гэх вэ?

Өртөг нь ч өндөр болох ийм шинжтэй. Тийм учраас боломжит хямд өртгөөр цэвэрлэх байгууламж, дэд бүтцийг нь барих ажилд шуударч ороод байна. Анх удаа 24 оны төсөв дээр энэ цэвэрлэх байгууламжийн төсөв хөрөнгө санхүүжилт тавигдаад байгаа, 24 онд. Тэгэхээр 25 он гэхэд Дарханы арьс ширний үйлдвэр ашиглалтад орох ийм боломж нь бүрдэнэ гэдгийг бас хэлье.

Энэ хүртэл, 25 он хүртэл арьс ширнийг чөлөөтэй, гадагшаа, ямар ч квотгүй, хориггүйгээр чөлөөтэй гаргахыг Засгийн газрын тогтоол гарсан байгаа шүү гэдгийг бас хэлье. Энэ намраас арьс ширний үнэд бас тодорхой өөрчлөлт өнгөрсөн жилийнхээс илүүгээр орно гэж итгэл төгс байна.

Хүнсний хувьсгал. Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хувьсгал, Улсын Их Хурлын баталсан Хүнсний хангамж, аюулгүй байдлын 36 дугаар тогтоол амжилттай хэрэгжиж байгаа. Эндээс одоогийн байдлаар өнөөдрийн байдлаар 500 гаруй тэрбум төгрөгийг хөдөө аж ахуй, хүнс үйлдвэрлэгчдэдээ 6 хувийн хүүтэй 3-5 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээл олгоод байна. Нэг талаасаа бид нар зээл олгох нэг хэрэг, хөнгөлөлттэй зээл. Нөгөө талаасаа бас гаднаас орж ирж байгаа импортын хүнсний зүйлийг тодорхой хэмжээнд хязгаарлаж, импортын татварыг үечилж хангамжтайгаа ... /минут дуусав/

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Тэгэхээр энэ Арцсуурь боомтоор хямд гурил орж ирж, Завхан аймгийн иргэд бусад иргэдээс илүү энэ үнэтэй хоол, хүнс идэж байгаа энэ асуудлыг бас та шийдэж өгнө гэдэгт итгэж байна.

2 дугаарт нь, энэ малын өвчлөл гэдэг асуудал бас л олон жил ингээд яригдаж байгаа. Монгол мал мах ингээд амттай, шим тэжээлтэй, чанартай

гэдгийг хөрш орнууд маань гадаад улс орнууд мэдээд авахыг хүсээд байхад яагаад бид нар тэдний тавьж байгаа тэр стандарт гэдэг юмыг хангаж чаддаггүй юм бэ? Энэ нь юунаас болдог юм бэ? Үүнийг яг энэ телевиз үзэж байгаа нийт малчдад сайд та хэлж өгөөч ээ. Тэгээд малын өвчин энэ жил гарахгүй гэсэн баталгаа байна уу? Бүх тарилга, туулга вакцин нь бүрэн хийгдсэн үү гэдэг асуултад бас хариулт авъя.

Г.Занданшатар: 84.

А.Нарантуяа: Сайн байцаана уу. Би Мал эмнэлгийн ерөнхий газрын болон ер нь гоц халдварт өвчний талаар гишүүний асуусан асуултад хариулъя. Монгол Улсад 22 оны эцсээр 4 гоц халдварт өвчинтэй, ялангуяа шүлхий өвчин 200 голомт, бог малын мялзан 115 голомт, хонины цэцэг 78, үхрийн арьс товруутах өвчин 1 голомттой байсан. Яг өнөөдрийн байдлаар Монгол Улс гоц халдварт өвчнөөр тайван байна. Үүний төлөө Мал эмнэлгийн ерөнхий газар болон яамны зүгээс төрийн бодлогын зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд ялангуяа шүлхий өвчинтэй тэмцэх арга хэмжээнд олон улсын төсөл хөтөлбөр байгууллагаас 9 сая, үндэсний өөрийн улсын төсвөөс 5,5 сая, нийтдээ 15,5 сая шүлхийн вакцин ...

Г.Занданшатар: Товч тодорхой хариул, нэмэлт хариулт минутад багтааж хариулах ёстой шүү дээ.

Тайвширсан уу? Зүгээр зүгээр тавьчих, мэдэж байгаа, товч тодорхой хариул. 1 дүгээрт өөрийгөө танилцуул. Протоколд тэмдэглэж үлддэг учраас наадах чинь ингээд автоматаар унтраад байх юм. Протоколд хэн гэдэг хүн хариулаад байгаа нь сүүлд нь баримт болж үлдэнэ шүү дээ. Тэгээд товч тодорхой асуултад хариулна. 84 гүйцээж хариулъя.

А.Нарантуяа: Тэгээд ерөнхийдөө хаврын вакцинжуулалтад 5,5 сая, намрын вакцинжуулалт 6 сая вакцин

дархлаажуулалтдаа гарсан байна. Тэгээд одоогоор шүлхий өвчин байхгүй байна. Ерөнхийдөө яагаад олон улсын худалдааны хорио цээрт 2 өвчний асуудал дээр ингээд худалдаанд хориг тавиад байдаг вэ гэхээр Дэлхийн мал, амьтан эрүүл мэндийн байгууллагаас энэ 2 өвчин дээр худалдааны хориг тогтоодог. Тэгээд энэ стандартыг биелүүлэхийн тулд мал эмнэлэг өөрөө стратеги батлуулах ёстой. Тэгээд бид нар шинэчилсэн стратегиар ажиллаж байна. Одоогоор өвчин байхгүй байна.

Тэгээд олон улсын зарим хэлэлцээр, мал эмнэлгийн гэрчилгээ, протокол санамж бичигт зарим улстай бид нар хамтарч ажиллаж байна. Тэгээд гишүүнд ер нь энэ талаар бас тодорхой мэдээлэл хүргүүлье. Мал эмнэлгийн ерөнхий газар Нарантуяа.

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Энэ дөрөвхөн минутын хугацаанд энэ мал аж ахуй тэр дундаа малчдын асуудлыг бас яриад, асуугаад хариулахад бас их хязгаартай байна л даа. Тийм учраас ганцхан асуулт асууя, Хөдөө аж ахуйн сайдаас.

Энэ 21 аймаг, 9 дүүрэгт Болорчулуун сайд аа, нэг энэ зоорины асуудлыг шийдэж болохгүй юу, төрөөс. Өнгөрсөн жилийн инфляцын 14, 5 хувийн өсөлтөд махны үнэ хамгийн их чухал нөлөөтэй байсан, өндөр үнэтэй байсан. Яагаад гэхээр энэ малчид, орон нутгууд зорьгүйгээс болоод хавар мах үнэд ордог, ногоо үнэд ордог. Хэрвээ хямд мах идье гэвэл, хямд ногоо идье гэвэл зортой байж байж, хямд үед нь нөөцөлж аваад үнэ өсгөхгүйгээр хямд үнэтэй мах, төмс, хүнсний ногоо идэх бололцоо боломж байгаа юм. Тийм учраас үүнийг яамнаас төрөөс Засгийн газраас бодлогоор орон нутгуудад зорь барих, зорьтой болгох асуудлыг хийгээч. Ингэж чадвал зөвхөн энэ малчдын гар дээрээс махыг авахаас илүүтэйгээр бас орон нутгийн,

нийслэлийн энэ сургууль, цэцэрлэг, эмнэлгүүдийн бас нэг тулгамдсан асуудал энэ зоорьгүй учраас тэр дундаа хавар үнэтэй мах идэж байгаа юм. Мах нь олддоггүй. Тийм учраас энэ эрхлэгч, захирлуудын нэг тулгамдсан асуудал бол энэ махны асуудал байдаг. Хүүхдийн хоолны үйлдвэрлэл дээр гэх мэтчилэн маш олон талын ач холбогдолтой учраас ХААЯ-наас энэ зоорьтой болох асуудал дээр онцгой анхаарал хандуулж ажиллаач. Ажиллах бололцоо боломж байна уу? Танай яамны төлөвлөгөө юманд байна уу л гэдгийг би асуух гэсэн юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун сайд хариулна.

Х.Болорчулуун: Сандаг-Очир гишүүний асуулт үнэхээр зөв өө. Аливаа юманд саалиа бэлдэхээр саваа бэлд гэж Монгол ардын зүйр үг байдаг. Зоорь гэдэг махан дээр ч, ногоон дээр ч, бусад хүнс дээр ч гэсэн маш чухал. Тийм учраас Хүнсний хангамж, аюулгүй байдлын тухай 36 дугаар тогтоол дээр зоорийг тусгайлан зоорь барих ААН-үүдэд хүүгийн хөнгөлөлт олгохоор зээлийн хүүгийн хөнгөлөлт олгохоор ингэж 50 тэрбум төгрөг тавьсан байгаа. Гэхдээ энэ нь одоогийн байдлаар 10 орчим тэрбум төгрөгийн буюу 20 хувийн л гүйцэтгэлтэй байна. Тэгэхээр зоорь барихад улсаас бариад өгөх биш. Бид социализмын үе шиг. Зоорь барих аж ахуйнууд нь өөрсдөө барина. Харин 5 жил хүртэл хөнгөлөлттэй 6 хувийн хүүтэй зээлийг олгоно. Энэ бас удаашралтай байсан нэг шалтгаан нь манай энэ хөдөө аж ахуйнхан барьцаа зээл, хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө, байшин барилга муутай байдаг учраас зээлээ авахад бас хүндрэлтэй байдаг. Санасан зээлээ авч чаддаггүй. Харин энэ 9 сараас, энэ сараас Зээлийн батлан даалтын сан манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам дээр ирж байгаа. Тийм учраас энэ зоорь барих сонирхолтой ААН, иргэдэд 6 хувийн хүүтэй зээл олгохоос гадна 60 хүртэл хувиар хөнгөлөлттэй зээл, Батлан даалтын сан өмнөөс нь зээлийн батлан

даалт гаргах болно гэдгийг бас сонордуулъя. Баярлалаа.

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууна.

Ц.Сандаг-Очир: Харин тийм, та бүхэн энэ жилийн гүйцэтгэл чинь хорьхон хувьтай байна гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө л батлан даалт байдаг юм уу, барьцаа хөрөнгөгүйгээс болоод энэ жижиг дунд ААН-үүд чинь зээл авч хийж чадахгүй байна шүү дээ. Тийм учраас ер нь төрөөс хийж өгөх ёстой юмнууд нь байна. Нэгд, дэд бүтцийг төр зайлшгүй татах ёстой орон сууцжуулах бодлого дээр. Тэгвэл энэ хүнсний асуудал дээр мах, ногоон дээр энэ зоорийг бас төрөөс би хийж өгөх ёстой л гэж хувьдаа боддог.

Дараа нь тэр хийснийхээ дараа тэр менежментийн хувьчлал юмаар нь гэдэг юм уу, хувийн хэвшилүүд цаашидаа аваад явах асуудлыг нь дараа нь шийддэг юм байгаа биз. Ер нь зүгээр өөрсдөө одоо зээл байгаа ингээд өөрсдөө барь аа гээд ингээд хаячихаар чинь энэ чинь явахгүй байна шүү дээ. Цаана нь эцсийн эцэст жил болгон л махны хэрэгцээ шаардлага, хүнсний хэрэгцээ шаардлага жил болгон яригддаг. Тэгээд л бахь байдгаараа байдаг. Ингээд 50 тэрбум тавиад байхад жилийн хугацаанд хорьхон нь гараад, 10 тэрбум нь гараад хорьхон хувийн гүйцэтгэлтэй байна гэдэг энэ чинь хангалтгүй л байна шүү дээ.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун сайд хариулна.

Х.Болорчулуун: 50 тэрбумаас юу маханд, махан дээр 9 тэрбум, ногоон дээр 19 тэрбум нийт 19 тэрбум шүү. Өөрөөр хэлбэл 39 хувь нь гараад байна гэсэн үг. Одоогийн байдлаар. Зээлийн батлан даалтын сан энэ 9 сард манайд ирчихлээ. Тэгэхээр үүнийгээ ашиглаад бид нар маш хурдацтай бас өргөн гарах боломж бүрдэж байгаа гэж хэлж болно л доо.

Г.Занданшатар: Тлеуханы Аубакир гишүүн.

Т.Аубакир: Баярлалаа. 4 минутад асуугаад энэ Монголын хөдөө аж ахуйн бүх асуудлыг ярина гэх ч боломжгүй л дээ, Сандаг-Очир гишүүн бас зөв хэлж байна. Хэд хэдэн тодорхой асуулт байна. Ажлын хэсгээс эхлээд хариулмаар байна.

Болорчулуун сайдын хувьд үндсэндээ бодлого зангидаад сууна. Доор нь байж байгаа манай газар, хэлтсийн дарга нар санал санаачилгатай, гүйцэтгэл сайтай ажилласан бол зохицуулчхаж болох ажил энэ Монголын ХАА-д бас байгаад байдаг юм. Тийм учраас газар, хэлтсийн дарга нарыг өөр өөрсдөдөө хамаатай асуултууддаа нэг хариулаадхаач.

Энэ малын эрүүл мэндтэй холбоотой Мал эмнэлгийн газраас өнгөрсөн жил 42 тэрбум төгрөг төсөвлөгдсөн танайд. Үүний гүйцэтгэл хэдэн хувьтай байна? Гүйцэтгэгдээд үндсэндээ малын энэ халдварт өвчин маань хэдэн хувьтай багассан юм бэ? 1 дүгээр асуулт.

Энэ махны экспорттой холбоотой. Өнгөрсөн жил миний бие мал махны экспортын ажлын хэсгийг ахалж ажилласан. 160 сая орчим долларын махыг үндсэндээ өнгөрсөн жил Монгол Улс экспортолсон байдаг юм. Энэ жилийн хувьд жишээлбэл Хятад улс руу ингээд идэш уушны цаг эхэлнэ, мал нядалгаа эхэлнэ. Хятад улс руу экспортлох, Хятад улсаас ирж аттестатчилдаг энэ үйл явц яг ямар түвшиндээ явж байна. Миний сонсох нь ээ урагшаа Хятад улс руу тэр аттестатчилах үйлдвэрүүдийнхээ нэр усыг явуулаагүй гэсэн байдалтай. Гэтэл ингээд наадмын маргааши намар гэж ингээд нядалгаа бойны цаг эхэлдэг. Нөгөө ААН-үүдийн зохих ёсны зөвшөөрөл нь ирээгүй байдаг. Ингээд экспорт удааширдаг. Энэ аттестатчилах ААН-үүдийнхээ саналыг яагаад явуулахгүй байгаад байгаа юм бэ? Энэ дээр 2 дахь асуулт тодорхой хариулаад өгөөч.

Энэ хүнсний ногоочдыг дэмжих зээлтэй холбоотой Болорчулуун сайд аа,

үнэхээр хүртээмж муу байна, үнэхээрийн муу байна. Энэ дээр өнгөрсөн жил Монгол Улсын Засгийн газраас мал аж ахуй дээр жишээлбэл 132,3 тэрбум төгрөг, хүнсний ногоон дээр мөн бас хөнгөлөлттэй зээл өгсөн. Мал аж ахуй ч тэр, хүнсний ногоон дээр ч тэр энэ арилжааны банкны шалгуурыг давдаггүй ерөөсөө. Жижиг ААН-үүд 10, 20 га-тай байдаг юм уу, 5, 10 га-тай хүмүүс эндээс зээл аваад амьжиргаагаа залгуулах ямар ч боломж байхгүй. Барьцаа хөрөнгө гэж байдаггүй. Арилжааны банкны зээл шалгуур ойлгож байгаа юм. Жижиг дундаас авхуулаад зээл будилаантай болсноос хойш Монгол Улсын Засгийн газар байдаг юм уу, бодлогын яамд нь ер нь банктэйгаа хамтарч ажиллая аа гэж байгаа юм. Мааш хатуу шаардлагатай. Гэтэл өнөөдөр яг энэ ногоог чинь тарьж байгаа ногоочид маань тэр зээлийн шалгуурыг хангаад механикжуулалтаа сайжруулах, усалгаагаа сайжруулах, саяын Сандаг-Очир гишүүний хэлж байгаа зорь, савныхаа асуудлыг шийдэх янзлах ямар ч боломж байхгүй байгаад байгаа юм. Бид нар энд яриад л байгаа, яриад л байгаа, Улсын Их Хурал, Засгийн газраас мааш олон шийдвэрүүд гарч байгаа. Бүх ажлууд очоод дунд шатны албан тушаалтнууд дээр очиж гацдаг. Одоо сүүлийн үед бүр ил цагаандаа гарсан. Шийдвэр ... /минут дуусав/

Г.Занданшатар: Нэмэлт 1 минут байхгүй. Нэмэлт нэг минут байхгүй. Хариулт хангалтгүй бол тодруулж асууна.

Хэн хариулах вэ. 84. Товч тодорхой хариулаарай.

Мал эмнэлгийн ерөнхий газар Нарантуяа. Ерөнхийдөө мал эмнэлгийн төсөвлөсөн төсвийн гоц халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд 34,9 сая мал хамруулахаас 28,3 хувь сая мал хамруулаад байна. Гүйцэтгэл 81,2 хувьтай. Түрүүн би бас мэдээлсэн. Гоц халдварт өвчний ерөнхий 4 өвчин голомтын тоо 22 оныхоос 3 дахин

өвчилсөн мал, амьтны тоо 93 хувиар буурсан байгаа.

Ер нь гоц халдварт өвчингүй байна. Хэрэгжүүлж байгаа арга хэмжээ бол шүлхий өвчинтэй тэмцэх дархлаажуулалтын ажил, намрын дархлаажуулалт явж байгаа учраас яг нийт төсвийн тоо одоохондоо хараахан гараагүй байна. Сарын дараа гэхэд бүх нэгдсэн мэдээ гарна.

Г.Занданшатар: 82 гүйцээж хариулъя.

Сайн байцгаана уу. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Довчинсүрэн.

Энэ жилийн хувьд нийт малын тоо 71 сая. Нийт бэлтгэх малын тоог 17 сая 250 мянган толгой гэж үзэж байгаа. Энэ нь болохоор нэг 543 мянган тонн гэж. Дотооддоо нийтдээ хэрэгцээлэх мал гэвэл нэг 11490 гэж тооцоолж байгаа. Энэ нь болохоор тоонд шилжүүлбэл нэг 364 мянган тонн. Экспортлох боломжит нөөц нь гэхээрээ малын тоо нь болохоор 5 сая 762 буюу нийт 179 мянган тонныг экспортлох бүрэн боломжтой гэсэн тийм тооцоо судалгаа ерөнхийдөө гарчихсан байгаа.

Энэ жилийн хувьд БНХАУ руу экспортлох эрх авсан асуудал ямар түвшинд явуулж байна энэ тэр гэж. БНХАУ-ын Гаалийн ерөнхий газраас 248, 249 дүгээр тушаалаараа тус тус баталсан ийм журам гарсан. Тэр нь болохоор 2022 оны 01 дүгээр сараас эхлээд тус улсад хүнсний бүтээгдэхүүн импортлох аж ахуйн нэгжийн нэг цонхны цахим системд бүртгүүлж, Монгол Улсын хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэхүү цахим системд бүртгүүлсэн аж ахуйн нэгжид баталгаа гаргаж, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газарт цахим хүргүүлж ажиллаж байгаа. БНХАУ-ын Гаалийн ерөнхий газраас 2023 онд эрхтэй 4 аж ахуйн нэгжид шинээр ингээд хүсэлт

гаргасан. Сая өчигдөр буюу 1 ААН дээр цахим шалгалтыг явуулсан байгаа. Энэ бол Булган Мах маркет дээр цахим шалгалт бол явуулсан. Ингээд нийтдээ 5 ААН-үүдийн хүсэлтийг нь явуулчихсан.

Энэ 248, 49 дүгээр тушаал нь болохоор нэлээн хэдэн тийм нарийн тийм асуумж асуудалтай. Үүнийгээ болохоор яг нэг ААН-үүд бөглөж ирэхдээ жоохон алдаатай юмнууд бөглөсөн. Үүнээсээ болоод нэлээн буцаагдсан асуудлууд нэлээн байгаа. Тийм учраас яг 5 ААН яг бүрэн бүрдүүлээд өгчихсөн байгаа. Нийтдээ бид нар яг энэ жилийн хувьд нэг 8 ААН энэ 5-аасаа гадна 8 ААН өгсөн. Тэд нарын энэ буцаагдаж ирсэн комментууд байгаа. Энэ яг ААН-үүдээс өөрөөс нь шалтгаалсан асуудлууд байгаа.

Г.Занданшатар: Тлеуханы Аубакир гишүүн тодруулна.

Т.Аубакир: Энэ хөдөө аж ахуйн салбар гэдэг бол цаг нартай уралдаж ажилладаг ийм л байгууллага л даа. Тийм учраас миний түрүүн хэлээд байгаа энэ дунд шатын дарга нар ажилдаа жоохон шуурхай сэтгэлтэй хандмаар байна. Ерөөсөө бүх яамд дээр ялгаа байхгүй. Яг дунд шатны газар, хэлтсийн дарга нар ерөөсөө шийдвэр гаргадаггүй, улс төржөөд л түүнийгээ худлаа мушгиад л ингээд байгаад сурчихсан шүү дээ, та нар бол.

Энэ хяналтын юутай холбоотой энэ салбарын хяналт ер нь юу болж байна. Энэ жил чийг бороо ихтэй байсантай холбоотой янз бүрийн өвчнүүд их болсон. Энэ жил яг та бүхний хавар хэлж байсан байдаг юм уу зун ургац тогтоол дээр хүлээж байсан ургацаа энэ жил Монгол Улс хурааж авч чадахгүй. Гурилын үйлдвэрүүд улаан буудайгаа авахгүй байгаа, 1 дүгээрт.

2 дугаарт, Болорчулуун сайд аа, ер нь энэ улаан буудайд өгдөг урамшууллыг бэлэн мөнгө хэлбэрээр нь биш бордоогоор өгдөг болмоор байна. Бэлэн мөнгө өгдөг, трактор техник хүүхдийн сургалтын

төлбөртөө төлдөг. Бордоогоор нь өгөөд байх юм бол Монгол Улсын газар маань хэдэн жилийн дараа үржил шимтэй болно оо л гэсэн үг. Бэлэн мөнгө өгөөд байхаасаа илүү бодлогоо энэ рүү чиглүүлмээр байна. Сая хяналттай холбоотой дахиад хариулаад ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун сайд хариулна.

Х.Болорчулуун: Аубакир гишүүний асуултад хариулъя. Түрүүнд хүнсний ногооны дэмжих зээл бас сайн гарахгүй байна гэж байна. Хүнсний ногоон дээр б хувийн хөнгөлөлттэй зээлийг бас олгож байгаа. Тэгэхдээ банкнууд өгнө. Банканд нь хүүгийнх нь хөнгөлөлтийг зөрөө өгч байгаа.

Ногооны үрийг 80 хувь хөнгөлж олгож байгаа. Мөн хүнсний ногооны техникийг 50 хувь үнийг нь чөлөөлж байгаа. Энэ бодлогын үр дүнд хүнсний ногоо энэ жил 165 мянган тонн авах буюу түүхэндээ 82 хувиар дотоодын хэрэгцээг хангах ийм бодлого юу урьдчилсан баланс гарсан шүү гэдгийг бас хэлье. Одоо харин борлуулалтаа дэмжиж урдаас ижил төстэй ногоо оруулах дээр бас тодорхой хэмжээнд босгыг нь өндөрсгөх ийм ажил байгаа гэдгийг бас хэлье.

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн. Батсуурь гишүүн минут чинь дууслаа шүү. Товчхон тодорхой хариул аа. Асууж байгаа хариулж байгаа 2 нь хаа хамаагүй юм асуугаад байх юм.

Батсуурь гишүүн нэрээ татаж байгаа юм байна. Тэгвэл 85 хариулъя. 85 хариулъя. Тодорхой хариулахгүй бол.

Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын хяналтын газрын дарга Санчирдорж байна.

Аубакир гишүүний асуултад би хариулъя. Тэгээд энэ салбарт бол манай салбар төлөвлөгөөт болон төлөвлөгөөт

бус хяналт шалгалтыг хийж байгаа, үр будаа дээр. Ялангуяа энэ экспортод гарах энэ махны үйлдвэрүүдэд аттестатчиллын шалгалтыг явуулна. Энэ 10 сарын 20-ноос энэ шалгалт эхлэх гэж байгаа. Цаашидаа энэ Хятад улсаас экспортыг дэмждэг энэ компаниудыг эрхийг олгодог биш Монгол Улс өөрсдөө энэ экспортыг гаргадаг эрхийг бий болгоно гэсэн зорилготой ажиллаж байгаа.

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн асуулт асууна.

Ж.Батсуурь: Өнөөдөр энэ хөдөө аж ахуйн чиглэлээр бас энэ асуулт, хариулт явж байгаа. Тэгээд олон гишүүдтэй санал асуултууд давхардаж, зарим тайлбарууд авагдлаа. Орон нутагт бэлтгэлийн даац хэтэрч байгааг бүх хүмүүс ярьж байгаа. Тэгэхээр энэ Улсын сайн малчин шалгаруулдаг үзүүлэлтээ өөрчлөөч ээ. Малын тоо толгойгоор өгдөг биш, хэдэн хүнийг амьдралд хүргэсэн, ямар хэмжээний чанар чансаатай үүлдэр угсаа бий болсон, орон нутагтаа нэр хүндтэй, хойч үедээ үлгэр дуурайлалтай мөн нүүдэлчин Монгол ахуй, бэлчээрийн мал аж ахуй, эрчимжсэн мал аж ахуй хосолж байгаа. Энэ талаас нь онцгой анхаарахгүй бол олон хүн энэ мянгат малчин гэдэг цолын төлөө, улсын сайн малчин, аймгийн сайн малчин, сумын малчин гэдэг сайн цолны төлөө явах гэж байгаад хохирсон, мөн бодлого нь буруу байна гэж ингэж хэлэх гээд байна. Энэ дээр онцгой анхаарал хандуулаач ээ гэсэн. 1 дүгээр асуулт.

2 нь, энэ хөдөөд малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин хийдэг. Гэтэл энэ вакцин нь тээвэрлэлтдээ байдаг юм уу, хадгалалтдаа байдаг юм уу өвчнөөс хамгаалах биш тэнд өвчнийг үүр болгож тарьж байна. Жишээлэх юм бол буглаа үүсдэг. Тэр вакцинаас болж. Тэгээд буглаа үүснэ гэдэг чинь тэнд хүнээр бол халуурч бүлээрч байна гэсэн үг. Тэгээд бүр нөгөө тарга тэвээрэгт нь нэмэр болох биш, онд ороход нь нэмэр болох биш тэнд зориудын

өвчин аваачиж өгч хүнд гай болж байна. Тийм болохоор энэ вакцины үйлдвэрлэлд тээвэрлэлт, хадгалалт, мөн түүнийг тэр тухайн малд хүргэж тарих тал дээр онцгой анхаарах хэрэгтэй байна, анхаарах хэрэгтэй байна.

Дээр нь хөдөөд бол нөхцөл байдал энэ Улаанбаатар хотод байгаа энэ төв орон газар байгаа ойрхон газруудаас шал өөр шүү дээ. Аль мянган км-т даяар 200км-т тэр хэдэн малын эмч нар чинь хүргэж чадаж байна уу, үгүй юү, тэрийг тээвэрлэж чадаж байна уу, үгүй юү, түүнийг хийж байгаа зүйлүүд нь юу болж байна вэ гэсэн энэ тал дээр анхаарал байна.

3-д нь, ноосны урамшуулал одоог хүртэл өгөгдөхгүй байна. Энэ хэзээ өгөгдөх вэ? Үүнийг ер нь цаашид өгөх юм уу, өгөхгүй юм уу? Хэрвээ өгдөг бол хугацаанд нь өгдөг байвал яасан юм бэ гэж.

4-д нь, түүхий эдийн үнийг өндөрсгөнө өө гэж ингэж онцгой амлалт өгч гарч ирсэн, танай эрх барьж байгаа Ардын нам. Мөн түүнээс гарсан Хөдөө аж ахуйн үе үеийн сайдууд. Өнөөдөр өндөрсөх биш бүр хогийн цэг дээр очлоо. Тэгээд үүнийг ойрын хугацаанд ямар арга хэмжээ авах гэж байна вэ гэсэн ийм 4 ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Жамбын Батсуурь гишүүний асуултад хариулъя. Тэр улсын аварга малчин шалгаруулдаг журмыг эрс өөрчилж байгаа. Ялангуяа энэ 24 оны улсын аваргын шалгаруулалтыг тэр малын тоо олондоо биш, нийгмийн хариуцлагын өмнө нь хүлээсэн үүрэг, сум, орон нутагтаа бас хаялаг. Энэ чинь ус бэлчээр гээд л нийтийн эзэмшлийн л юмыг хэрэглэж байгаа шүү дээ. Тэгэхээр бас мянгат малчин дотроо 2 янз байдаг. Зарим нь гар чангатай, зарим нь хаялгатай, сум орон мөн ойр дотнынхоо малчдад ийм хаялгатай,

нийгмийн хариуцлагаа ухамсарласан байдаг. Тэгэхээр энэ явдлыг улсын аварга шалгаруулах явдлыг журмыг эрс өөрчилж байгаа. 24 оноос тоог урьтал болгохгүй ээ гэдгийг бас хэлье. Тооны хойноос хөөцөлдөхгүй.

2 дугаарт, энэ вакциныг чанаргүй байна, буглаа үүсэж байна, өвчлөл гарч байна гэж байна. Бид ер нь нэг л юм ажигласан юм, энэ яаман дээр. Яагаад 2 жилийн өмнө 21 аймагт бүгдэд нь шүлхий өвчин гарав, яагаад энд тэндгүй 16 оноос хойш өмнө байхгүй байсан мялзан өвчин гарав. Энэ бол төрөөс үзүүлж байгаа, төрийн өмнөөс ажил хийж байгаа малын эмч нарынхаа ажлыг үнэгүйдүүлчихсэн юм билээ. 1 хонь тарихад 250 төгрөг, 1 үхэр тарихад 450 төгрөг. Энэ нь болохоор малын эмч нар тойроод ингээд 1000 мал тарихад, 2000 мал тарихад нөгөө зардлаа дийлэхгүй. Тийм учраас хийсвэр тарилга явагддаг байдал нь ажиглагдсан.

Аймгуудын мал эмнэлгийн складад 1 биш аймаг дээр хугацаа хэтэрсэн вакцин тарилга гэнэтийн шалгалтаар бий болсон нь харагдсан. Үлдсэн нь харагдсан. Тийм учраас энэ 24 оны төсөвт бүр онцгой анхаарч 1 хонийг тарихад 250 байсныг 350 төгрөг болгож байгаа. 1 үхэр тарихад 450 байсныг 1000 төгрөг болгож байгаа. Ингэснээр төрийн өмнөөс үйлчилгээ үзүүлж байгаа хувийн мал эмнэлэг хөгжих үндэс суурь бүрэн бий болно. Малын эмч нар урам зоригтой бас ажилдаа эзэн болж ажиллана. Малын эмчид ярьж байна. Одоо бол 1 ч малыг үлдээхгүйгээр график тарилгаа хийнэ шүү дээ гэж хэлж байгаа байхгүй юу. Тэгэхээр урьд нь үлдээдэг л байсан байхгүй юу.

Тэгэхээр энэ вакцины чанар, үйлчилгээ, хүртээмж сайн болно гэдгийг бас энэ үйлчилгээний хөлстэйгөө уялдуулан сайжрах болно гэдгийг бас хэлье.

Ноосны урамшуулал гээд олон жил өгсөн, энэ дээр үр дүн олигтой бас гараагүй ээ. Ноосны урамшуулал тэгээд яг малчид дээрээ бас тэр болгон очихгүй,

цөөхөн хоньтой малчид дээрээ очихгүй, олон малтай бол авдаг. Хоршоо гэсэн байдлаар дунд нь ченжүүд авдаг ийм явдал бас түгээмэл байсан. Тийм учраас бас энэ хөдөө аж ахуйн урамшууллыг дотор нь ингэж яам бас эрэмбэлж багцаар нь төсөв дээр суулгасан байгаа. Ялангуяа энэ дотроос сүүний урамшууллыг нэмэгдүүлэх замаар бас ажиллах ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Засгийн газрын тогтоол гарсан байгаа гэдгийг бас хэлье.

Түүхийн үнийн үнэ унасан шалтгаан бол арьс ширний үнэ бас унасан байдал бол тэр 13 онд Засгийн газрын тогтоол гараад бүх төрлийн арьс ширийг гадаадад гаргахыг хориглочихсон юм байна лээ. Үүнийг өнгөрсөн намар 11 сард чөлөөлсөн, манай яамнаас санал оруулж чөлөөлсөн. Тэгэхээр энэ намрын арьс ширний үнэ тодорхой хэмжээнд өснө өө гэж итгэл төгс байна. Бид арьс ширний томоохон үйлдвэр ашиглалтад орж дотооддоо боловсруулах хүртлээ тэрийг хааж боогоод яах юм бэ. Энэ дээр бас ийм либералчилсан байр суурь баримталж байгаа шүү гэдгийг бас хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн тодруулж асууна.

Ж.Батсуурь: Тийм, энэ улсын сайн малчны шалгуур үзүүлэлтийг эрс өөрчилнө гэж байна. Энэ хугацаагүй боллоо. Тийм учраас маш богино хугацаанд өөрчилсөн энэ шалгуур үзүүлэлтээ маш сайн сурталчилмаар байна. 1 дүгээрт бүтцийн байгууллагуудаараа анхан шат хүртэл хүргүүлэх, бүх багийн дарга нар т хүргэх.

Дээр нь энэ болсон болоогүй янз бүрийн сурталчилгаанууд телевизээр маш их явах юм. Энэ улсын сайн малчин, аймгийн сайн малчин, сумын сайн малчин шалгаруулах энэ болзолт бодлогоо энэ телевизүүдээр маш богино хугацаанд бараг оноос өмнө сурталчилгаа, мэдээллээ өгөх хэрэгтэй байна. Тэгэхгүйгээр 1 бичиг явуулчихдаг, тэр бичиг нь аймагт Хөдөө аж ахуйн газар дээр дарагддаг. Хөдөө аж ахуйн газар нь

сум руугаа явдаг, очоод тэр нь хэдэн багийн дарга нар очтол аль уе хүн нь шалгарчихсан байж байдаг. Тийм учраас үнэхээр тийм нууцлал биш юм бол ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах? 83.

Сайн байцаана уу. Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Наранчулуун байна.

Батсуурь гишүүний асуултад хариулъя. Улсын аварга малчны журмыг цахимжуулж байгаа, журамд нь өөрчлөлт оруулсан. Яамдаас санал авах түвшинд одоо байна. Таны саналаар тэр сурталчилгааг сайн хийнэ гэсэн бодолтой байна.

Ноосны урамшууллын бас асуудал яригдсан, түрүүн. и-баримтаар үүсгэгдсэн ноос борлуулсан баримтуудыг шалгаж байгаа юм байна, 10 сардаа багтааж олгоно оо гэсэн ийм хариултууд байна

Г.Занданшатар: Өнөөдөр ингээд ярьж л байх ёстой асуудал л даа.

Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн асуулт асууна.

Б.Энх-Амгалан: Би ажлын хэсгээс асууна. Мал эмнэлгийн ерөнхий газраас, Наранчулуун дарга энэ тэрээс асууя. Та хэд маань маш товч тодорхой хариулаад өгөөрэй. Малыг эрүүлжүүлэхгүйгээр бид нар эдийн засгийн эргэлтэд оруулна гэж хэзээ ч байхгүй. 71,1 сая толгой мал тоологдлоо гэж байна, сайн. Гэхдээ бид нар ингээд 4 гоц халдварт өвчний голомттой, тэгээд ОУБ энэ дээр хориг тавьчихдаг юм аа гээд суугаад байдаг. Энэ Олон улсын байгууллагатайгаа ажиллахгүй юм уу? Энэ хоригуудаа цуцлуулахгүй юм уу? Тусгай ногоон грийн гэрчилгээ энэ тэр авахгүй юм уу. Энэ малыг эрүүлжүүлэх үйл ажиллагаа дээр энэ олон улсын итгэмжлэгдсэн лаборатори байгуулахгүй юм уу? Вакцины

үйлдвэр байгуулахгүй юм уу? Тэгээд 1 хэрэгтэй, хэрэггүй чанартай, чанаргүй вакцин шахуулаад энэ вакциныхаа вакцин шахдаг энэ бүлэглэлээ зогсоохгүй юм уу. 42 тэрбум төгрөг та нар малын эрүүлжүүлэх хөтөлбөр дээр тавигдлаа шүү дээ. Сая та хэлээд зогсож байна. 9 сая доллар Олон улсын байгууллагаас авч вакцин хийлээ гэж байна. Тэгээд энэ чинь ингэдэг бол наадах чинь эрүүлжчихсэн байх ёстой шүү дээ. Энэ дээр ямар арга хэмжээ авах гэж байгаа юм? Нэг дэх асуулт.

2 дахь асуулт. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, экспортод гаргах асуудал бол цэвэр үйлдвэрлэлийн асуудал шүү дээ. Юу яриад хямд өртгөөр цэвэрлэх байгууламж барина гэж яриад байна вэ? Хямд өртгөөр цэвэрлэх байгууламж баривал та бүхэн тэр малын зунгаг ноосыг салгаж байгаа химийн бүтээгдэхүүн, тэр арьс ширний хром сульфидыг тэгээд л гол руу л цацна шүү дээ. Өөр яах юм. Энэ чинь дэлхийн технологи гарчихсан шүү дээ. Хайгаад байх юм байхгүй. Битүү технологи гарчихсан, буцаад хэрэглэдэг технологи нь гарчихсан. Тэр хэзээ байгуулагдах юм. Дэлхийд байхгүй технологи олох гэж байгаа юм биш шүү дээ.

Тэр Дарханы чинь үйлдвэр дээр хэчнээн төгрөг тавьдаг юм, хэзээ орох юм. Энэ Эмээлт дээрээ хэзээ орох юм. Энэ байхгүй бол экспортод гаргах тухай яриад ч хэрэггүй.

3 дахь асуудал. Энэ малчдын залуу хоолойг бэлтгэнэ гээд яриад байдаг. Та бүгдийн танилцуулга дээр энэ залуу малчдын сургалтын хэрэгцээг тодорхойлж, олон улсын төсөл хөтөлбөрөөр дамжуулан малчдад зааж сургана. Мал маллахыг заана гэж ямар юм байдаг юм. Энэ малчдын эрх ашгийг хамгаалах, байгалийн нөөц ашиглах заяагдмал эрхийг хамгаална. Нинжа болгох гээд байгаа юм уу. Эд нарт чинь 2 л том асуудал байгаа шүү дээ. Нэг нь, бэлчээрийн асуудал байгаа юм. Олон малтай энэ малчид нь тэр залуу малчид

чинь бэлчээр өгөхгүй байгаа байхгүй юу. Өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслан нь болж өгөхгүй байгаа юм. 2 дахь нь тэр эхнэр, хүүхдийнх нь асуудал байна шүү дээ. 1 сумд 70-80 залуу малчин эхнэргүй байна гээд ингээд. Энэ чинь төрийн бодлогоор хангахгүй бол энэ чинь залуу малчдыг бэлтгэх тухай олон улсын төсөл хөтөлбөрөөр зааж сургах тухай асуудал байхгүй байхгүй юу.

3 дахь нь, усалгаатай тариалан эрхлэх асуудал ярьж байгаа юм. Усалгаатай тариалан эрхэлж байж энэ ногоон тэжээлийг тарих энэ асуудал ярьж байгаа шүү дээ. Энэ Ёлтон, Цахир 2 дээрээ төслийн нэгжээ байгуулахгүй юм уу. Энэ чинь явж байгаад аягүй бол тэгээд хувьчлагдаад тэгээд юу ч биш юм болгох гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ дээрээ нэг арга хэмжээ авахгүй юм уу? Энэ ногоон тэжээлийг чинь тариалж байж л мал жсоохон өвөл тэжээлтэй болох ийм асуудал яригдах гээд байна шүү дээ. Нийт бэлчээрийн 70 хувь доройтчихсон. Тэгэхээр усалгаатай тариалан дагаж хөгжүүлэхгүй л бол энэ чинь явахад хэцүү болчихоод байгаа байхгүй юу. Ийм 4 асуултад нэг хариулаад өгөөч.

Г.Занданшатар: Ажлын хэсэг 84. Нарантуяа Мал эмнэлгийн газар.

Мал эмнэлгийн ерөнхий газар Нарантуяа. Гишүүний асуултад хариулъя. Ер нь 23 оны байдлаар өвчний голомт Монгол Улсыг бүрхсэн байсан. Өнөөдөр гоц халдварт өвчингүй байгаа. Энэ бид нарт маш ахиц гарч байгаа. Яагаад гэхээр 41,7 тэрбум төгрөгийн өнөөдрийн байдлаар санхүүгийн хувьд 80 хувийн гүйцэтгэл гарчихсан. Зарим ер нь хамрагдах малын 30 хувийг л дархлаажуулалтад хамруулдаг. Бид нар бүх малаа, мэдрэмтгий малаа дархлаажуулалтад хамруулах тийм эдийн засгийн боломж байхгүй. Тийм учраас энд мал эмнэлгийн тархвар зүү тийм том эвтэмлогийн судалгаан дээр үндэслээд дархлаажуулалтын ажлыг сайн хийсэн. Үүн дээр 1 дүгээрт нь шүлхий өвчинтэй тэмцэх стратеги, бог малын

мялзан өвчинтэй тэмцэх стратегийг бүтэн өөрчлөөд энэ жил бас мэдээлэлд бид нар хүргэсэн байгаа. Яагаад гэхээр мялзан өвчин өөрөө тэмцэх тэр вакцин нь гадаадын тийм Йордан улсаас авсан вакциныг авсан байгаа. 3 жилийн дархлаажуулалт вакцин хийхгүйгээр дахиж стратеги шинэ вакцин оруулсан байгаа.

Эдийн засгийн хоригийг цуцлахдаа тодорхой хугацаанд Дэлхийн мал, амьтан эрүүл мэндийн байгууллагад бид нар шаардлагад нь нийцүүлж асуумж бөглөдөг. Тийм учраас тэр хугацаа арай болоогүй байгаа учраас өнөөдөр энэ улсын бодлого байх ёстой. Зарим нэг тохиолдолд ганц 2 тохиолдлыг мэдээлэхгүй байх. Энэ бол үндэсний бас бодлого байх ёстой. Мэдээлээд байх юм бол бид нарын олон улсын худалдааны хориг цээрт өвчин дээр хориг тавиад байгаа учраас маханд нөлөөлнө. Одоо өнөөдрийн байдлаар, яг өнөөдрийн байдлаар 20 гаруй орон руу экспорт хийж байна. Баянхонгор аймаг жишээлбэл вакцингүй эрүүл бүс дэлхийн том том брэндүүд Шанель, Хермес гэхэд Баянхонгор аймгийн ноолуурыг авах гэж булаацалдаж байгаа. Энэ маш ахиц байгаа. Тэгээд бас ер нь сайн мэдээлэл өгмөөр байна. Бүгд хамрагдаагүй, бүх мал өвчтэй биш байгаа.

Вакцины үйлдвэрийн тухайд ярьж байна. Улсын мал эмнэлэг ариун цэврийн лаборатори бүх аймаг шатандаа Монгол Улсын мал эмнэлгийн лаборатори маш сайн. Ялангуяа BSL 3 дугаар зэргийн манай энэ лаборатори ер нь Азидаа дээгүүр орох лаборатори байгаа.

Био үйлдвэрийн тухайд бүтцийн хувьд яамны мэдэлд очсон байгаа. Био үйлдвэр дээр зарим нэг тийм шугаман эсийн үс үрэлт технологийн өөрчлөлт хийх асуудлыг яригдаж байгаа. Тэгээд ер нь цаашид вакцины үйлдвэр ямар байх вэ. Орчин үеийн хялбар технологит үйлдвэрийн асуудал дээр мэргэжлийн хувьд санал өгч байгаа.

Г.Занданшатар: 83, Наранчулуун.

Г.Наранчулуун: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Ер нь залуу малчдыг түрүүн бас хэдэн хувийг эзэлж байна гэж асуулт гарч байсан. 30 хүртэлх залуучууд залуу малчид 12 хувийг эзэлж байна. Тийм учраас бид нар энэ залуу малчдын чадавхыг сайжруулах ямар юм сурахыг хүсэж байгаа талаар нь судалгаа авсны үндсэн дээр 9 чадамж бүхий залуу малчдын сургалтын хөтөлбөр гэдэг асуудлыг Эрдэмтдийн багаар боловсруулж энэ батлуулсан байгаа. Тэгэхээр энэ хөтөлбөрөө баримтлаад бүсчилсэн болон залуу малчдын сургалтыг бас энэ жил зүүн болон төвийн бүсэд явуулсан. Сая энэ залуу малчдын зөвлөгөөний үеэр бас энэ хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан сургалтынхаа материалуудыг бас олгосон байгаа.

Бэлчээрийг яаж хамгаалах вэ гэдэг асуудал яригдлаа. Тэгэхээр бэлчээрийн даацыг нэмэгдүүлэхийн тулд мэдээж малын тооны өсөлтийг зохицуулах шаардлага эдийн засгийн эргэлтэд оруулах шаардлага үүсэж гарч байгаа. Тэгэхээр өсвөр малыг бордох, ялангуяа хурга, шүдлэн бярууг нас гүйцсэн малын хэмжээнд хүргэж бордох ажлуудыг Өвөрхангай, Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Архангай, Булган аймгуудад хэрэгжүүлж байна.

Мөн ногоон тэжээл тариалах, дарш бэлтгэх энэ сургалтуудыг явуулж байна. Ер нь энэ сургалтуудыг голдуу энэ Олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд санхүүжилтээр хийгдэж байгаа гэдгийг бас онцолж хэлмээр байна.

Г.Занданшатар: Болорчулуун сайд гүйцээж хариулъя.

Х.Болорчулуун: Энх-Амгалан гишүүн түрүүнд нөгөө арьс ширний үйлдвэрийн талаар асуусан. Улс бол тэр үйлдвэрийг бүхэл бүтнээр нь бариад байх ямар ч шаардлагагүй ээ. Урьд нь улсын үйлдвэр барих байдлаар нэлээн л төсөв

мөнгийг нь их болгочихсон 500 тэрбумаар босгох ийм үйлдвэрийн зураг төсөв явж байсан. Зөвхөн цэвэрлэх байгууламж нь гэхэд, цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмж гэхэд 17,5 сая доллароор гэрээ урьдчилсан байдлаар хийгдчихсэн байсан. Яг газар дээр нь очоод бас энэ намар манайхан ажилласан. Яг адилхан 3000 м3-ийн хүчин чадалтай Евро стандартаар хангасан Италийн үйлдвэрийг 6,5 сая еврогоор тоног төхөөрөмж авах ийм боломж саналыг нөгөө үйлдвэр нь ирүүлж байх жишээтэй. Тэгэхээр хэмнэлттэй бодит санхүүжилтээр арьс ширний цэвэрлэх байгууламжийг барина гэдгийг хэлэх гэж байгаад нөгөө хямд өртгөөр гээд ташаа хэлсэн юм шиг байна. Тэгэхээр бас улс ч гэсэн энэ цэвэрлэх байгууламжийг барихдаа бас бодит үнээр аль болохоор хэмнэлттэйгээр евро стандарт хангасан тийм цэвэрлэх арьс ширний цэвэрлэх байгууламж барина.

Дээр нь хувийн хэвилийнхэн гадаад орон Итали ч тэр, Турк ч тэр яг үйлдвэрээ бараг мөнгө төлөөд уралдаж тендерээр ордог юм байна лээ. Энэ байдлаар бас ажиллана гэсэн ийм, ажиллаж байгаа гэдгээ хэлье.

Г.Занданшатар: Гочоогийн Ганболд гишүүн асуулт асууна.

Г.Ганболд: Баярсайхан гишүүн их зөв асуудал хөндсөн. Тэгээд бид нар ингээд сонсоод нэг хариулсан болоод орхимооргүй байна, Их Хурлын дарга аа. Их Хурлаас ер нь тогтоол гаргаж энэ малчид руу чиглэсэн тэр дундаа энэ залуу малчдыг дэмжсэн ийм Засгийн газрын хөтөлбөр гаргаж санхүүжилттэй нь уг нь шийдэж явмаар байгаа юм.

Яг Баярсайхан гишүүн 4 асуулт асуусан байгаа юм. 1 дүгээрт нь яг малчид руу та нар яг юу хийсэн бэ гэж. Ойрын үед бид нар сая Нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд нэг малчдын нийгмийн даатгалын 50 хувийг төрөөс даадаг болсон. Энэ бол сайн. Үүнээс өөр ингээд юм байхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр

энэ хөтөлбөр гаргаад ингээд Засгийн газар, яам болгон үүрэг хариуцлага хүлээгээд явчих юм бол ХААЯ нь зөвхөн малжуулалтынхаа асуудлыг, ЭМЯ залуу малчдын нийгмийн даатгалын асуудлыг шийдээд явдаг. Харилцаа холбооны яам гэхэд энэ үүрэн холбоо, харилцаа холбооны сүлжээг орон нутагт бий болгох тал дээр онцгой анхаарал хандуулах шаардлагатай байгаа юм. Одоогийн нийгэм бол энэ тэр дундаа залуучууд энэ сошиал орчинд их орж, мэдээлэл авах ийм хандлага асар их байна. Гэтэл Харилцаа холбооны яам болох дээр зэрэг Улаанбаатар хотод л ингээд хурдан үйлчилгээ гээд баахан цэг нээгээд байдаг. Яг нарийндаа энэ дэд бүтцийн яам. Хөдөө байгаа энэ залуучуудыг үүрэн холбоотой болгох тал дээр жишээлбэл Харилцаа холбооны яам анхаарал хандуулах хэрэгтэй байх юм. Барилга, хот байгуулалтын яам гэхэд энэ хөдөө энэ отор нүүдэл ихтэй болсонтой холбогдуулаад энэ явуулын тийм байр, зөөврийн, энэ дээр нь бас ингээд нэг санхүүгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлдэг гээд яам болгон өөрсдөө одоо Боловсролын яам гэхэд энэ хүүхдүүдийн дотуур байрны асуудлыг гэх мэтчилнээр бүгд нэг үүрэг хүлээгээд шийдээд хөтөлбөр болгоод томоохон санхүүжилт хийгээд явах юм бол энэ залуу малчдыг дэмжих тал дээр нэг тодорхой ахиц дэвшил гарна гэж ингэж хараад байгаа юм.

2-т нь, энэ орон нутгийн үйлдвэрүүдийг дэмжих чиглэлээр сая Ерөнхий сайд очоод Өвөрхангайд махны үйлдвэр бүх төрлийн үйлдвэр байна бүгдийг нь дэмжинэ гэсэн. Энэ тал дээр жишээлэх юм бол Өвөрхангайн махны үйлдвэр Ирантай 200 мянган богийн гэрээ хийгээд явж байна л даа. Гэтэл яг гаргах гээд ирэх дээр зэрэг ингээд хил, гааль дээр нөгөө бүрдүүлэлт хийдэг компаниуд нь заавал энд ирж тэр Өвөрхангайн зооринд байгаа махыг энд авчирч зооринд хийсний дараа дээж авч ингэж гаргана гээд бөөн хар гацаа, түгжээ болоод байх юм. Ядаж нэг энэ нэг юмнуудаа нэг ингээд гацаагүй

явдаг ийм юм руу шилжмээр байна аа. Энэ дээр та нар нэг анхаараач.

Дараагийн асуудал нь энэ сая гишүүдийн хэлж байгаа ноос, арьс ширний урамшуулал. Үүнийг юу яриад байгаа юм бэ, яам. Энэ чинь хуультай. Төсөв дээр мөнгө нь батлагдчихсан. Зүгээр л өгөх хэрэгтэй байхгүй юу. Багцаар нь батлуулчихаад ингээд дурын юманд зарчихаад сүүлд нь заавал нэг ингээд нэг эсэргүүцэл, тэмцэл, жагсаал цуглаан болгож малчдаар баахан эсэргүүцэл болгосны дараа нэг өгдөг ийм жил болгон нэг ийм жишиг хандлага руу яваад байгаа байхгүй юу. Тэгээд үүнийг болиод батлагдсан мөнгө нь байгаа юм чинь эд нар үг дуугүй өгмөөр байна шүү дээ. Яаралтай.

Тэр хяналт шалгалтын залуу ярьж байна л даа ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Хаянгаагийн Болорчулуун сайд. Махны экспорт дээр.

Х.Болорчулуун: Ганболд гишүүний асуултад хариулъя. Бас ингээж Их Хурал дээр энэ асуулгад яриад, асуултад хариулж өнгөрдөг биш хөтөлбөр гаргаж байж ажиллаж гэж байна. Сая залуу малчдын чуулган өнгөрсөн 7 хоногт зохион байгуулагдсан. Эндээс залуу малчдад энэ мал аж ахуйд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх 10 хөтөлбөр бүхий тийм ажлыг төлөвлөөд ажиллаж байна гэдгийг бас хэлье.

Сая Ерөнхий сайд Өвөрхангай аймагт ажилласан. Энэ үеэрээ Өвөрхангайн махны үйлдвэрийг бас сайн ажиллаж байгааг нь харсан. Ялангуяа энэ Өвөрхангайн махны үйлдвэрийг анх Ганболд гишүүн Өвөрхангай аймгийн дарга байхдаа бас манай яаманд санал болгож байж яамнаас бас тодорхой дэмжлэг аваад энэ үйлдвэрийг анх байгуулж ажилласан өнөөдөр амжилттай ажиллаж байгаа. Ер нь тэгээд эзэн нь менежер нь зөв хүн байгаад байвал төрийн буюу орон нутгийн өмчит

газар ч гэсэн, үйлдвэр ч гэсэн ингээд амжилттай ажиллаж болдгийг энэ Өвөрхангайн энэ махны үйлдвэр харуулж байгаа юм л даа. Тэгээд хажуудаа арьс ширний үйлдвэртэй ингээд консорциум болоод ажилладаг. Ирантай 150-200 богийн гэрээ хийгээд ажиллаж байна. Үүний дээж авах ч гадагшаа гарах асуудал дээр манай яам тэгээд наашаа авчир гэсэн тийм хүндрэл байхгүй шүү. Тийм юм огт байхгүй гэдгийг бас хэлье.

Тэр гаалийн хажууд нөгөө хуучин мэргэжлийн хяналтаас хилийн хорио цээрийн гээд гааль руу нэг мэргэжлийн хяналтынхан очсон. Тэд нар л тийм асуудал тавьсан байх. Түүнээс биш яамны зүгээс тийм хүнд, аль болохоор хүнд сурталгүй үйлчил гэсэн тийм үйлчлэх чиглэлээр ажиллаж байгаа гэдгийг бас хэлье.

Энэ махны болон арьс ширний үйлдвэрлэл амжилттай ажиллаж байгаа үйлдвэр дээр 6 хувийн хүүтэй зээлийг бас ингээд Зээлийн батлан даалтын сангаар 60 хүртэл хувиар батлан даалтыг нь гаргаад, хангаад ингээд зээл өгөх боломжтой. Энэ чиглэлээр ажиллана гэдгийг бас хэлье.

Яах вэ, ноос, арьс шир, буудайн урамшуулал гээд л ингээд олон урамшуулал байна. Энд маш нарийн тавьчихаад, зарим нь илүүдээд, зарим нь дутах яг амьдрал дээр байдаг юм, хэрэгжилт дээр. Тэгээд ер нь багцаар нь тавьж байгаа. Гэхдээ мэдээж бид нар өгч байсан урамшууллаа өгнө. Гэхдээ бас энэ дээр бас зарим нэг урамшуулал Засгийн газрын тогтоол гараад сүүн дээр 500 төгрөгийг 1000 болгохоор ингээж гарсан байгаа гэдгийг бас хэлье. Өшөө нарийн мэдээллийг манай ажлын хэсэг хариулчих.

Г.Занданшатар: Ажлын хэсэг хэн хариулах юм. Гочоогийн Ганболд гишүүн тодруулж асууя. 1 минут.

Г.Ганболд: Үгүй ээ, ер нь яах вэ, тэр ноос арьс ширний урамшууллыг өгчих хэрэгтэй. Бид нар өнгөрсөн жил ч гэсэн

ярьж байгаад л мөнгийг нь хангалттай л тавьж өгсөн шүү дээ. Тэгээд сая хяналт шалгалтынхан мэргэжлийн хяналт тараад танай дээр хяналт шалгалт очсон. Түрүүн Аубакир гишүүний хэлж байгаагаар нөгөө махны үйлдвэрүүдийг зөвшөөрөл авах асуудлыг яаравчилмаар байна шүү дээ. Сүүлийн 2, 3 жил 1 ч үйлдвэрүүдээр гацаа зөвшөөрөл гарсангүй шүү дээ. Гэтэл та бол бид нар өөрсдөө шийддэг болох гэж байгаа юм яриад суугаад байх юм, наадах чинь үлгэр ээ. Авах гэж байгаа газар нь өөрсдөө стандарт шаардлага тавьж ямар үйлдвэрээр бэлдэхээ шийддэг юм шүү дээ. Хятадууд өөрсдөө ирж энд байгаа үйлдвэрүүдээ бэлдэж материалыг нь явуулж тэр Хятадын талыг авчрах тал дээр л анхаарах хэрэгтэй байхгүй юу. Хятадын тэр хил хорио цээрийнхэн гаалийнхныг Монголд яаралтай авчраад байх нь чухал. Түүнээс энд та нар тэгж олон юм яриад бол хэзээ ч бүтэхгүй ээ. Тэгээд энэ дээр та нар сайд бас онцгой анхаарал хандуулж энэ гадаадад экспортод гаргах зөвшөөрөлтэй олон ААН-үүд бий болох юм бол өрсөлдөөд гарна. Одоо бол нэг хэдхэн Хятадын компаниуд л байна шүү дээ. Ер нь нарийн ... /минут дуусав/

Г.Занданшатар: 82 хариулна. Ажлын хэсэг.

Д.Довчинсүрэн: Ганболд гишүүний асуултад хариулъя. Сая энэ махны үйлдвэр нэмэгдүүлэх гэж яг таны хэлж байгаа зөв л дөө. Нөгөө яг импортлогч орон нь өөрсдөө нөгөө шаардлага тавьдаг., Яг үүнийхээ дагуу нөгөө бүртгэлдээ бүртгүүлээд экспертүүд нь хүрч ирж үзээд тэгээд тэндээ болохоор нөгөө нэг яг шаардлага хангасан үйлдвэрүүдийг бүртгэж авдаг. Сая нийтдээ бид нар 13 үйлдвэрийг, сая энэ жил дээр явуулсан. Тэр 248, 49 дүгээр журмынх нь дагуу нэлээн олон тийм асуумжууд байдаг. Үүнийх нь дагуу нэлээн олон тийм сургалтуудыг хийсэн. Бас нөгөө ОУБ буюу Ай Ви Эф Си Эд нар гээд байгууллагуудтай хамтраад бүх энэ юунуудын махны боловсруулах

үйлдвэрүүдийг бүгдийг нь цуглуулж байгаад яг энэ асуумжууд нь яг энэ дээр нь ингэж хийнэ шүү гэсэн байдлаар бүгдэд нь зөвлөмж, зөвлөгөө өгч сургалтуудыг хийж явсан.

Сая энэ 3 дахь өдөр болохоор Булган аймгийн Хутаг-Өндөр сум дээр яг анхны ийм цахим шалгалтуудыг хийчихсэн.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Махны 13 үйлдвэр экспортод гаргадаг байсан. Одоо 19 үйлдвэр болж байгаа гэдгийг бас хэлье. Гэхдээ Хятадын мэргэжлийн хяналтынхан урьд нь орж ирээд үздэг байсан, ер нь бас нэг аль үйлдвэрээс аль улсын ямар үйлдвэрээс авахыгаа бас сонгодог зарчим бий. Гэхдээ Монгол Улсын өөрийн бас бодлого гэж байх ёстой. Тийм ч учраас бүх махны үйлдвэрүүд дээр хавраас эхлээд хяналт шалгалт, аттестатчилал ЭМЯ-тай зүгээр хамтарч явж байгаа. Тэгээд завсарлаад 10 сарын 20-ноос эхлэх юм. Үйлдвэрүүд жигдрэхээр. Тэгэхээр энэ юу вэ гэхээр үндэсний хэмжээнд нэг экспортод гарах ингээд чадамж стандартын шаардлага хангасан үйлдвэрүүд гэж, чадахгүй үйлдвэр гэж ингэж ангилж байгаа. Тэгээд чадахгүй үйлдвэрийн балгаар нэг үхрийн эвэрт доргивол мянган үхрийн эвэр доргино гэгчээр өнгөрсөн жил Эмээлтийн махны чанараас болж ... /минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайхан үг хэлнэ.

Б.Баярсайхан: Баярлалаа. Малчдын өмнө тулгамдаж байгаа асуудлаар нийт малчин түмнээ, тариаланч түмнээ төлөөлж Завхан аймгийн малчин, тариаланчдын асуусан асуулт, хүсэлт саналыг Засгийн газар

уламжилж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Болорчулуунд тавьсан асуулгаар өнөөдөр чуулган хуралдаж өгсөнд баярлалаа.

Өнөөдөр бид эрүүл Монгол Улс байя, эрүүл хүнтэй байя гэвэл хүнсний эрүүл аюулгүй байдлыг заавал анхаарах шаардлагатай. Ийм цаг үед байна. Малчид байгаа болохоор бид малтай байж, мал байгаа учраас бид өдөр тутамд дэлхий дээрх хамгийн чанартай мах гэж тооцогддог бэлчээрийн малын махыг хүнсэндээ хэрэглэж байгаа. Тийм учраас бид малчин, мал бэлчээрийн асуудалд онцгой анхаарч үзэх шаардлагатай.

Бид өнөөг өнөөдрийн байдлаар 80 сая шахам малтай. Гэтэл уур амьсгалын өөрчлөлт малын тоо толгой нь өсөлт нь бэлчээрийн даац хэтрэх бэлчээр доройтох шалтгаан болоод ингээд удаж байна. Монгол Улс нэн яаралтай бэлчээрийн менежментээ хийж, эрчимжсэн тоонд биш чанарт суурилсан мал аж ахуйг хөгжүүлэх дорвитой алхам хийх ёстой байна. Сүүлийн хэдэн жил бид ган зудтай нүүр тулж байна. Ковидоос хойш цаашид уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр байгалийн гамшигт үзэгдлийн тоо 2030 он гэхэд 40 дахин нэмэгдэнэ гэсэн судалгааны дүнг НҮБ-аас зарласан. Тэгэхээр энэ уур амьсгалын асар хурдацтай өөрчлөлтөд Монгол Улс бэлэн үү гэж бид өөрсдөөсөө асуух цаг болсон.

Мал аж ахуйн салбарт дорвитой шинэчлэл хийж, малчдын орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх, малын ашиг шим, үүлдэр угсааг сайжруулж, өнөөдөр 500 малаас авч байгаа ашиг шимийг яаж илүү цөөн тооны малаас авах вэ гэдэг арга технологийг бид яаралтай нэвтрүүлэх шаардлагатай байна.

Малчдын залуу халаа, дараагийн үеийг бэлтгэх нь өнөөдрийн бид нарын хамгийн тулгамдсан асуудал болоод байна. Өнөөдөр нийт малчдын 60 хувь нь эрэгтэй, 40 хувь нь эмэгтэй байна. Хүйсийн тэнцвэргүй байдал нь энэ гэр бүл

зохиоход хүндрэлтэй байдлыг залуу малчдын өмнө үүсгэж байгаа. Энэ мэт малчдын нийгмийн асуудлыг орхигдуулах нь цаашилаад мал аж ахуйн салбарт ихээхэн хохирол авчрах ийм байдалд ирсэн байна.

Өнгөрсөн өвөл Завхан аймгийн хэд хэдэн сумдад малчид байгаль цаг уурын асар их хүндрэлтэй нүүр тулсан. Малчдын хувьд жил бүр тавьдаг гол асуудал бол өвс, малын тэжээлийн хангамжийн асуудал байдаг. Болорчулуун сайдын сая хариулснаар 100 сумд энэ тэжээл тарих боломжоор хангах гэж байгаа юм байна. Тийм учраас Завхан аймагт энэ ажлыг нэн түрүүнд хийж өгөөч ээ гэж ингээж хүсээж байна.

Мөн малын гаралтай түүхий эд үнэгүйдэж байгаа тухай малчид сүүлийн жилүүдэд байнга ярьж байна. Аймгуудад болон бүсчилсэн хэлбэрээр малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэр, бэлтгэн нийлүүлэх баазуудыг барьж байгуулах шаардлагатай байна. Энэ талаар Засгийн газар, салбарын яам нь үр дүнтэй дорвитой ажил хиймээр байна.

Завхан аймагт 60 кг-тай гурил 120 мянган төгрөгийн үнэтэй байгаа нь иргэдийн амьжиргаанд хүнд тусаж байгаа талаар Их Хурлын гишүүний зүгээс би олон удаа ярьж байгаа. Тэгэхээр алслагдсан аймаг, сумдад гурилын үнийг тогтвортой байлгах талаар салбарын сайдын хувьд та бодитой ажил хийгээч. Үнэхээр үндэсний үйлдвэрлэж байгаа гурилаараа хангаж чадахгүй юм бол Арцсуурь боомтоор орж ирэх тэр квотыг та тогтоож өгөөч ээ гэж танаас хүсээж байна.

Эрүүл хүнс, эрүүл ногоо идэх боломжоор Монгол Улсын бүх иргэд хангагдах ёстой. Нутгийнхаа эрүүл хөрсөн дээр ургасан хүнсний ногоог идэхэд хамгийн чухлаар тавигддаг асуудал бол зоорины асуудал. Өнөөдөр олон гишүүд ярьж байна. Тиймээс манай аймгаас удаа дараа тавьж байгаа 1000 тонны

багтаамж бүхий механикжсан зоорь барих, газар тариалан эрхлэгчдийг дэмжих техник дундын төв байгуулах, ашиглагдахгүй байгаа инженерийн хийцтэй услалтын системүүдийг сэргээн засварлах, малын үүлдэр угсааг сайжруулах ажлуудад яам Завхан аймагт дэмжлэг үзүүлж ажиллахыг хүсье.

Тариалан эрхэлж байгаа иргэдэд олгох зээлийн шалгуурыг бууруулах бодитой шаардлага байна. Ажил хийе, тариа ногоо тарья гэж хүсэж байгаа олон хүмүүс байна. Гэвч банкны шалгуурыг давж чадахгүй, энэ олон сайхан нэртэй төсөл хөтөлбөрт Завхан аймгийн иргэд маань хамрагдаж чадахгүй байгаа гэдгийг энд онцлон дурдмаар байна.

Эцэст нь малын өвчлөл, махны чанарын талаар онцгой анхаарч, экспортод гаргах боломж нөхцөлийг хангаж ажиллах шаардлагатай байна. Малчны хотонд байгаа малын үнэ маш бага, мах худалдаж авахаар маш өндөр үнэтэй байдаг энэ үзэгдлийг хэзээ зогсоох юм бэ? Малчинд ашиггүй, иргэдэд ашиггүй, ченжээс өөр хэнд ч ашиггүй энэ тогтолцоог халж, малчин бүр үйлдвэрлэгч, нийлүүлэгч байх боломжийг бүрдүүлж ажиллах шаардлагатай байна.

Та хэдийгээр хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлж байгаа боловч Монгол хүний эрүүл мэнд, үндсийн үндэс болсон хүнсний аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдлын асуудлыг хариуцсан сайд гэдгээ ухамсарлаж, өндөр хариуцлагатай ажиллахыг хүсэж байна.

Эцэст нь энэ эдийн засгийн гол тулгуур болсон малчин, мал аж ахуй, хөдөө аж ахуйн салбарыг нуруундаа тээж яваа энэ 21 аймагт байгаа бүхий л малчид, тариаланчдаа сайн сайхныг хүсье. Энэ хүмүүсийг бодлогоор дэмжих зайлиггүй шаардлагатай гэдгийг бас онцлон хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын

Баярсайханаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандан тавьсан асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар сонслоо.

Ер нь энэ асуулт, хариултын явцад Улсын Их Хурлын олон гишүүн малчдын өмнө тулгамдаж байгаа үндсэн асуудлууд болох цөлжилт, бэлчээрийн доройтол, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний борлуулалт, үнэ, залуу малчдын халаа, малчдын нийгмийн асуудал, эрүүл мэнд, боловсролын асуудал, мал аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлж байгаа энэ бодлогуудын үр дүн, хэрэгжилтийн талаар олон чухал асуудлуудыг асууж ярилаа. Тэгээд энэ тоочоод байх юм бол малчдын өмнөх асуудлууд, нийгмийн асуудал, эдийн засгийн асуудал маш их асуудлууд байна.

Манай Ганболд гишүүн бас олон гишүүд энэ хөтөлбөр гаргая, Улсын Их Хурлаас хөтөлбөр гаргая, ажиллая, ажлын хэсэг гаргая гэсэн ийм саналууд тавьж байна. Тэгээд Монгол Улсад хөтөлбөр багадаагүй, цөөдөөгүй. Нэн ялангуяа хөдөө аж ахуйн салбар. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Монгол малчин үндэсний хөтөлбөр, Малчдыг дэмжих анхдугаар аян, Шинэ хөдөө хөтөлбөр, Хөдөөгийн сэргэлт ингээд уриа лоозон хөтөлбөр, асуулт хариулт ч гэсэн багадаагүй. Үүнийг бодитой хэрэгжүүлэх батлагдсан хууль тогтоомжуудын хэрэгжилт хангалтгүй байгаа. Хэрэгжилтийн арга механизмыг нь ч гэсэн зөв олж тодорхойлох хэрэгтэй байгаа юм. Ийм яриаг сүүлийн 30 жил бэлчээрийн хуулиа батлахаас авхуулаад, залуу малчдын халаа жилээс жилд буурч байгаа асуудал, нийгмийн асуудал олон жил ярилаа.

Сая залуу малчдын 10 хөтөлбөр баталсан гээд л тэгж байна. Залуу малчдыг дэмжих 10 хөтөлбөр нэг нэг өгүүлбэртэй 10 хөтөлбөр баталсан. Нэг өгүүлбэртэй хөтөлбөр ч гэж юу байлаа. Хэрэгжих арга зам, санхүүжилт, төсөв

төлөвлөгөөгүй тийм хөтөлбөрүүд ч гэж юу байлаа. Ингэж уриа лоозон дэвшүүлж ярьдгаа болмоор, хийдэг л болмоор байгаа юм.

Мал аж ахуй, хөдөөгийн сэргэлт, гоё, гоё үгийг зөндөө ярьж байна. Тэгээд үүний шийдэл нь бол дэлхийн олон улсын туршилага судалгааг бид парламентын судалгааны хүрээлэнгээр судаллаа. Малчдын холбоо, хоршоо, нэгдэл, Шинэ Зеландын, сүүлд Казахстаны энэ хөдөөгийн сэргэлтийн энэ бүх бодлого ерөөсөө л энэ эдийн засгийн энэ товар мөнгөний харилцааг бий болгохын тулд малчид нэгдэж хоршиж байж энэ бодит ажлууд хийгдэнэ.

Малын эрүүл мэндийн асуудал Нарантуяа дарга их сайхан болж байгаа гэж ярьж байна. Баруун бүс эрүүл бүс байсан. Одоо Баянхонгороос бусад аймаг өвчлөлтэй улс боллоо. Дэлхийн Малын эрүүл мэндийн байгууллагын стандартаар улсыг тэр чигээр нь биш тухайн бүс нутгийг л эрүүл бүсээр нь ингэж ялгадаг. Тэр чиглэлээр хийгдэж байгаа ажил юу байгаа юм.

Тийм учраас манай Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Улсын Их Хурлын дэд дарга бид нар ярилцаад бас манай Тогтохсүрэн дарга ч гэсэн бэлчээрийн мал аж ахуйн, бэлчээрийн хуулийн тухай асуудал дээр ажиллаж байгаа. Энэ чиглэлээр ер нь энэ малчдын болон хөдөөгийн сэргэлтийн бодлогыг дэмжих энэ бүлгэм байгуулж ажиллах нь зүйтэй. Үүний гол үндэс нь ерөөсөө малчдын холбоог бүх аймаг болгонд байгуулж, ганц нэгээрээ ярьдаг биш тэгээд нэгдсэн журмаар энэ асуудлыг шийддэг Малчдын холбоо, хоршоо, нэгдэл тогтолцоог дэмжих ийм тогтолцоо бий болгож байж явахгүй бол малчдын асуудал үндсэндээ хаягдсан. Тэгээд л хааяа үүнийгээ ярьдаг.

Хөдөөгийн хүн амын 50 хувь нь малчин өрхийн асуудал байгаа. Ийм учраас энэ маш их судалгаа гадаад, дотоодын туршилага судалгааг үзэхэд

ерөөсөө энэ одоогийн энэ сумын газар нутгийн зохион байгуулалт, бэлчээрийн зохион байгуулалт, нэгдэлд зориулаад хийчихсэн гэдэг. Сум, нэгдлийн түүх гэдэг энэ маш том түүхийн шинжлэх ухааны эрдэмтдийн хийсэн судалгаа байгаа. Хөдөө аж ахуйн их сургууль, манай Парламентын судалгааны хүрээлэн хамтраад энэ малчдын тулгамдаж байгаа асуудлуудыг шийдэх судалгаа хийсэн. Тэгээд Шинэ Зеланд, Нидерланд, Европын улсууд, Казахстан энэ олон улсын туршилага ерөөсөө Малчдын нэгдэл, хоршоог дэмжих замаар тэгж байж малыг эрүүлжүүлнэ, тэгж байж бэлчээрийн доройтол, хомсдолтой тэмцэнэ, усан хангамжийг сайжруулна, малчдын нийгмийн асуудлыг шийднэ, ингэж цогцоор шийднэ.

Ийм учраас энэ жалгын нэг тарсан малчин нэг нэгээрээ эрх ашгаа хамгаалаад тэмцээд л аль эсвэл асуудлыг нь бодлого болгоод явах ийм бололцоо хязгаарлагдмал. Тэгэхээр энэ 21 дүгээр зуунд энэ цахим боломж энэ тэр гарч байгаа энэ үед ингэж хэрэгжүүлэх. Япон, Солонгосын туршилага ч тийм. Ерөөсөө өдөө аж ахуй өөрөө хүнсний хангамжийн асуудал, сая сая хүний эрүүл мэндийн асуудал, хүнсний хангамж ирээдүйн том сорилт, бэрхшээл болж байгаа энэ үед энэ эрүүл мал аж ахуй, эрчимжсэн мал аж ахуй энэ бүх бодлогоо хөгжүүлэхийн тулд энэ Малчдын холбоо, хоршоо, нэгдлийг дэмжсэн ийм шийдэл гаргах хэрэгтэй юм байна лээ. Тэгээд энэ том төсөл болж хичээж байна. Ингэж байж түүхий эд бэлтгэл, хангамжийн тогтолцоо, ингэж байж тэр жишээлбэл Хөдөө аж ахуйн хоршоодын холбоодын дэргэд банктай. Манайх хуучин тийм байсан. Одоо ч гэсэн Япон, Солонгос, дэлхийн бүх улс банктай, даатгалтай, маркетинг худалдаа, бэлтгэл хангамжийн тогтолцоотой ингэж цогц тогтолцоо байж байж хөгжүүлэх байхгүй юу. Энэ талаар ерөөсөө ярьсангүй. Хэрэгжүүлэх арга замыг нь.

Нөгөө л ярьдаг уриа лоозон хөтөлбөр тэгээд л мал эрүүлжиж байна.

Мал, малын эмчийн асуудал бүтэн тогтолцоонд байгаа байхгүй юу. Тийм учраас энэ сум нэгдлийн тогтолцоог Үндсэн хуульд хүртэл заачихсан байдаг юм. Корпорацын чанараар ажиллах ёстой гэсэн ийм байдалтай. Тэгээд одоо улсаас гар харж амьдардаг болчихлоо. Бүх сумын төвүүдийг энэ нэгдэл хоршооны хөрөнгөөр боссон. Одоо бол дандаа сургууль, эмнэлэг, сургуулийн цэцэрлэг мөнгө улсын төсвөөс шийдэж байна шүү дээ. Ийм учраас энэ цогц шийдлийг, тогтолцооны шинэчлэлийг шинжлэх ухааны үндэстэй гарах асуудлыг Хөдөө аж ахуйн яам санаачилж, манлайлж ажиллах хэрэгтэй байна. Хөдөө аж ахуйн их сургуультай хамтарч, эрдэм судалгаатай хамтарч, бид нар судалгааны ажлыг нь үндсэндээ эхлүүлчихсэн хийчихсэн байгаа. Энэ талаар харин улс төрийн дэмжлэг манай хөдөөгөөс сонгогдсон гишүүд хамтраад ингээд нэг ийм цогц бүлгэм байгуулж ажиллая. Энэ том ажил болох юм байна лээ. Бүх аймаг, сумдад ухуулж холбоо. Одоо хэд хэдэн аймагт малчдын холбоо байгуулсан. Энэ шугамаараа мал эрүүлжүүлэх ажил хийгдэж байна.

Баянхонгор аймгийн Баянговь сумын хоршоо 700 малчин өрхтэй болсон. Ноолуураа 148 мянган төгрөгөөр зарж байгаа юм. Саяын тэр яриад байгаа Лоро Пиано, Ховдын дундын хоршоо байгаа гадаадад экспортолж гаргаж байгаа. Ийм бодитой ажлуудыг хийж байж мал аж ахуй үр дүнтэй, үр ашигтай болно. Тэгээд энэ талаар нэгдсэн том бодлого орохгүй бол одоо 30 жил ярилаа. Үүнийг эрс өөрчилж, хөдөөгийн сэргэлтээ хийхэд Хөдөө аж ахуйн яам санаачлаад Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хороо хамтраад ингээж хэрэгжүүлбэл энэ хотын төвлөрөл түгжрэл ч гэсэн саарна. Хөдөөгийн сэргэлт жинхэнэ утгаараа бий болно. Үндсэн механизм. Энэ дээр өнөөдөр энэ асуулгатай холбогдуулаад манай Ганболд гишүүн ч гаргасан санал дэвшүүлээ. Тэгээд энэ бүлгэмийг байгуулаад тэгээд бүр аймаг аймагтаа, бүс бүсээрээ энэ бодлогыг хэрэгжүүлэх энэ танилцуулгыг Хөдөө аж ахуйн их

сургууль Хөдөө аж ахуйн яамтай хамтраад ирэх 7 хоногтоо нэг хэлэлцүүлгийг зохион байгуулъя. Энэ асуулгыг бүр үр дүн болгож. Тэгээд нэгдсэн бодлогоо гаргая гэж үзэж байна.

Ингээд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонслоо.

Бусад асуудлыг дараагийн 7 хоногт хэлэлцэхээр хойшууллаа.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ